



САНЖИЙН

САНЖИЙН ДОВЧИН САЙДЫН ЭДИЙН
ЗАСАГ, УЛС ТӨРИЙН БАЙР, СУУРЬ



ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН
БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССС
УЛС ТӨРИЙН ТАЛААР ХЭЛМЭГДЭГСДИЙН
СУДАЛГААНЫ ТӨВ

САНЖИЙН ДОВЧИН САЙДЫН ЭДИЙН ЗАСАГ,
УЛС ТӨРИЙН БАЙР, СУУРЬ

Улаанбаатар 1994 он

ӨМНӨХ ҮГ

Гуч, дөчөөд оны улс төрийн хэрэг гэгчид өртөгдөн амь насаа алдсан олон сайчуудын нэг нь сайд С. Довчин билээ. Эдүгээ тэдний үйл ажиллагаа, үзэл баримтлал, байр суурийг түүхэн үнэний шалгуураар дэнслэн нягталж үнэн бодитой үнэлж байна.

С. Довчин нь малчин ардын ядуу хэсгээс гаралтай, хүсэл зүтгэлээрээ эрдэм боловсрол олж, төрийн түшмэлийн албанд туршлагажин, бичгийн түшмэлээс төрийн сайд хүртэл дэвшсэн санхүү эдийн засгийн том мэргэжилтэн Монголын төрийн нэрт зүтгэлтэн байв.

С. Довчин монгол улсын тусгаар тогтнол, эдийн засгийн талаар биеэ даах, үндэсний банк, мөнгө зээлийн системийг шинээр байгуулж төлөвшүүлэх, улсын сан хөрөнгийг арвижуулахад билэг оюунаа зориулж гарамгай хувь нэмэр оруулсан нэрт эдийн засагч байв. С. Довчин ид эрч хүчтэй ажиллаж байсан 1936 онд ажлын амжилт бүтээлээрээ өөрийн нэрэмжит газартай болсон Монгол улсын гуравхан хүний нэг юм. Монгол эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө эдийн засгийн хүч чадлыг нэмэгдүүлэхийн тулд чадах бүхнээ хийж байсан С. Довчинг улс төрийн хэрэгт баривчлахыг ЗХУ-ын Дотоод Хэргийн Ардын Комиссараас Сталинд тавьж зөвшөөрүүлэн, барьж хорих асуудлыг Чойбалсанд даалган гүйцэтгүүлжээ. Барьж хорьсны дараа Зөвлөлтийн Аюулаас Хамгаалах байгууллагын Чита хотын салбарт, дараа нь Москвад нууцаар аваачиж хоёр жил таван сар мөрдөн залхааж байгаад цаазласан юм. Гэтэл С. Довчинд холбогдуулсан улс төрийн хэрэг гэгч нь худал зохиомол байсныг нотолсон ЗХУ-ын Ерөнхий прокурорын хариуг үндэслэн түүний хэргийг хүчингүй болгон иргэний нь нэр төрийг сэргээн цагаатгажээ. С. Довчин бол Монголын орчин үеийн түүхэнд нэр нь мөнхжих гавьяат үйлстний нэг мөн. Түүний 1908—1939 он хүртэл хоёр төрийн үед төрийн түшмэлийн алба хашсан олон талт ажиллагаа, эх оронч сэтгэлгээг харуулах архивын баримт элбэг билээ.

С. Довчингийн Монгол эх орноо гэсэн сэтгэл зүтгэл, амжилт бүтээл нь Монгол улсын шинэ эдийн засгийн хөгжил, сан хөрөнгийн хуримтлалтай салшгүй холбоотой юм. Түүний амьдрал, үйл ажиллагаа, нийгэм улс төрийн байр суу-

рийг үнэлж цэгнэн хэвлэн нийтлэх асуудал бүр 1930-аад оноос эхэлсэн юм.

1. 1934 онд хэвлэгдсэн үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд Найрамдах засгийн 10 жилийн ойд зориулсан альбомд «Сангийн Яамны долоо дахь удаагийн сайд С. Довчин» гэсэн том өгүүлэл нийтэлжээ.

2. Төр засаг, намаас С. Довчингийн Сангийн Яамны сайдын албанд үр бүтээлтэй ажилласны 10 жилийн ойг тэмдэглэж байгаад нам, засгийн үнэн сонин 1936 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 1, 2 дугаар нүүрээ зориулсан юм.

3. Ардын хувьсгалын 16 жилийн ойд зориулсан «Хүндэт удирдагч Довчин» гарчигтай том өгүүлэл үнэн сонины 1937 оны 7 дугаар сарын 8-ны дугаарт нийтэлжээ.

4. С. Довчингийн мэндэлсний 80 жилийн ойд зориулж түүхч эрдэмтэн Л. Санжаа агсны бичсэн «Ардын төрийн ахмад зүтгэлтэн» өгүүлэл үнэн сонины 1975 оны 7 дугаар сарын 8, №161-т нийтлэгджээ. Сүүлийн үед С. Довчинг судалж байгаа эл зохиогчийн өгүүлэлүүд нийтлэгдэв. Үүнд:

5. Түүхэн бие хүн Санжийн Довчин «Санхүү, зээл, бүртгэл» сэтгүүл. 1989. №4.

6. Үнэнийг өчөөд хэлмэгдсэн нь «Ардын эрх» сонин 1990 10. 27. №48.

7. Санжийн Довчин гэж хэн бэ? «Засгийн газрын мэдээ» сонин 1994. 3. 1-нд тус тус нийтлэгдсэн юм.

С. Довчин бол Монгол улсын шинэ цагийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулсан монголын төрийн нэрт зүтгэлтэн, эдийн засагч байсны хувьд түүний амьдрал, үйл ажиллагааг бүхэлд харуулсан судалгаа хийхэд дурдсан сурталчлал, судлалын нийтлэл, бүтээлүүд чухал хэрэгцээ болох нь дамжиггүй. С. Довчингийн судалгаанд түүний ураг удам, хувийн намтар үйл амьдралтай холбогдох мэдээ баримт ховор байгаа учир Цагаатгах комиссын судалгааны төвийн хаягаар мэдээ материал ирүүлж туслахыг хүсэх ялдамд товхимолыг хэвлэн нийтлэх зардлыг гаргасан монгол улсын Сангийн Яаманд гүн талархал илэрхийлье.

С. Довчин Сайн Ноён Хан аймгийн Илдэн бэйлийн хошууны нутаг Есөн зүйл гэдэг газар 1895 оны VIII сард тайж Хасын хамжлага ард Санжийн хоёрдугаар хүү болон төрсөн. Одоогийн Өвөрхангай аймгийн Өлзийт сумын харъяат юм. Довчингийн эцэг Санж нь ядуу амьдралын эрхээр ан гөрөө хийх, бусдын мал маллах, арьс нэхий элдэх, хошуу тамгын газрын галч, хуяг зэрэг ажил хийж байжээ.

Санжийнх дөрвөн хүү, нэг охинтой ахмад нь Бандь, Довчин, Дорж, Готов, Аюур (эмэгтэй) нар болно. Тэд цөм ертөнцийн мөнх бусыг үзүүлжээ. Тэднийх бэйлийн хошууны нутаг Сангийн Далай, Дулаан хан, Сарын гол, Шанхын орчмоор нутагладаг, цөөвтөр малтай боловч амьдралын гол нь мал, бага зэрэг ан гөрөө хийдэг байв. С. Довчингийн ач болох Доржийн хүүхдүүд Лхамсүрэн, Батчулуун, Амаржаргал, Буянхүү, Чулуунхүү, Төмөрбаатар, Даваахүү нар төв хөдөөд ажиллаж, амьдарч байна. С. Довчинг улс төрийн хэрэгт баригдсаныг сонсоод ах дүү нар нь тас нууж, өөр хоорондоо бол ороост цөлөгдсөн юм байх гэж сэм ярилцдаг байжээ. Ийнхүү нуусны ачаар эсэргүүний ар гэр гэх мэт хавчлагад өртсөнгүй.

С. Довчин эцэг эхийн амьдралд туслахын зэрэгцээ 12 настайгаасаа гэрийн сургалтаар боловсрол олж, 1908—1912 онд хошуу тамгын газар, аймгийн чуулганд туслах ба жинхэнэ бичээч түшмэлийн алба хаших болжээ. Тэр өөрийн хичээл зүтгэлээр орос хэлийг сурч оросоор шаггүй ярьж ойлгодог байжээ. С. Довчин хошуу тамгын газар түшмэлийн алба хаших болсон авч ядуучуудын талаар хошууны эрх баригчдын явуулж буй бодлогыг шүүмжлэн буруушаасан нь хошуу ноён Норовжанцанд хавчигдах шалтгаан болжээ. Норовжанцан ноён С. Довчинг элдвээр өө сэв эрж, хэрцгий догшин авирлан дарлан хавчих болсноос хошуу тамгын түшмэлийн албанаас гарснаар барахгүй нутгийн жинчдийг дагаж төрсөн нутгаасаа зайлан явахад хүрч 1913 онд Нийслэл Хүрээнд ирж суужээ. Энэ нь С. Довчин ядуучуудын дунд төрж өссөн, тэдний амьдралыг сайн мэддэг бай-

сантай, нөгөө талаар аливаа хүнийг алагчлан үздэггүй төвшударга, төрөлхийн нь зан чанартай нь холбогдоно. С. Довчин Нийслэл Хүрээнд ирсэн даруйдаа Түмтийн өртөөнд улаач хийж байгаад удалгүй Нийслэл Хүрээний Хужирбулан дахь Сайн Ноён Хан аймгийн цэргийн хороонд бичээч, дараа нь цэргийн яаманд түшмэл, эх зохиох түшмэлээр 1914—1919 он хүртэл ажиллажээ. 1919 оноос өөрийн нутаг Илдэн бэйлийн хошуу тамгын газрын хүсэлтээр харъяат хошуундаа эргэж очиж хошууны мэйрэн түшмэлийн албыг нэг жил шахам хашжээ. 1920 оноос Сайн Ноён Хан аймгийн Цэцэрлэгийн чуулганд түшмэлийн алба хааж байхдаа 1921 оны зун өртөө зэрэг хамаг албыг тэгшлэн хуваах хэргээр Сайн Ноён Хан аймгаас тус Нийслэл Хүрээнд ирээд байхад нь Монгол Ардын журамт цэрэг Нийслэл Хүрээг чөлөөлж, хуучин төрийн аппаратыг татан буулгаж, ардын засгийг шинээр байгуулан хувьсгалт өөрчлөлт хийж буйг С. Довчин талархан угтаж сайн дураар 1921 оны YII сарын эхээр МАН-д гишүүнээр элсэн орж, 1921 оны YII сарын 11-нээс цэргийн яаманд ерөнхий хэлтсийн эрхлэгчээр орж ажиллан ардын засгийн албанд зүтгэх болжээ.

С. Довчингийн өсч бойжсон ХХ зууны эхэн үеийн Монгол орон нь нүүдлийн мал аж ахуй эрхэлсэн, хүн амын амьдрал харилцан адилгүй, цаг төрийн байдал ээдрээ төвөгтэй харийн түрэмгийлэгчдийн хөлд нэрвэгдсэн колони орон байв. С. Довчин бол хамгийн хүнд амьдралтай ядуучуудын дундаас төрөн гарч хүсэл эрмэлзлээрээ эрдэм боловсрол олж, төрийн түшмэлийн албанд туршлагажсан бичгийн сэхээтний нэг юм. Монголын мал аж ахуйн, түүхий эд, эд баялаг гадаад ертөнцийн анхаарлыг ихээхэн татаж байсан нь монгол орны худалдаа, эдийн засгийн гадаад харилцаа өргөжин тэлэхэд чухал нөлөө үзүүлэв. Нөгөө талаар колонийн дарлалыг эсэргүүцсэн үндэсний тусгаар тогтнолын төлөө эх оронч үзэл өргөжин тэлж Монгол орноо гадаад орны жишээгээр шинэчлэн хөгжүүлэх эрмэлзлэл эрэл хайгуулын үрээр зарим зүйл хэрэгжиж эхэлсэн билээ. Нийгэм, эдийн засаг, соёлын хүрээг хамарсан эл үзэл санаа тухайн үеийн бичгийн түшмэлийн нэг С. Довчинд чухал нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй.

С. Довчинг цэргийн яаманд татан авч ажиллуулсан нь Монгол орныг түйвээн сүйтгэж байсан харийн түрэмгий-

лэгчдийг хөөн зайлуулах ширүүн тэмцэл үргэлжилж байсан хүнд түгшүүртэй үед ардын цэрэг түүний удирдах бүрэлдэхүүнийг эх орон ард түмэндээ үнэнч, шударга эх орончдоор бэхжүүлэх хэмээсэн төр, засаг, намын зорилттой нийцжээ. Тухайн үеийн хамгийн их сэрэмжилбэл зохих хязгаар нутаг бол зүүн өмнө хязгаар байсан юм. С. Довчинг 1922 оны XII сарын 22-ны өдрийн Монгол улсын Засгийн Газрын 56 дугаар тогтоолоор зүүн өмнө хязгаарыг сэргийлэн хамгаалах цэргийг захирах сайдаар М. Дугаржавын оронд томилжээ. С. Довчин 1922 оны 12 дугаар сарын 29-нд тамга хэргийг хүлээн авч, эл ажлаа эхэлжээ.

С. ДОВЧИНГИЙН ХАШИЖ БАЙСАН СОНГУУЛЬ, ТОМИЛОЛТЫН АЖИЛ

1921 оны VII сарын 11-нээс 1922 оны 12 дугаар сард цэргийн яаманд хэлтсийн эрхлэгчээр, 1922 оны 12 дугаар сараас 1923 оны 3 дугаар сард Зүүн өмнөд хязгаарын цэргийг захирах сайд, 1923—1924 онд гадаад Яамны эрхэлсэн түшмэл (орлогч сайдтай тэнцэх тушаал), 1924—1926 онд Сангийн Яамны эрхэлсэн түшмэл, 1926—1939 онд Сангийн Яамны сайдаар ажиллахын хамт 1926—1930 онд Монгол банкны ерөнхий хорооны орлогч дарга, 1932—1939 онд жинхэнэ дарга, 1926—1935 онд БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн ерөнхий сайдын жинхэнэ орлогч сайд, орлогч сайдын ажлыг тус тус хавсран хашиж байжээ.

Эдгээр ажлынхаа зэрэгцээ цаг үеийн чанартай олон ажилд төр засгийн дээд байгууллагын шийдвэрээр томилогдон үр бүтээлтэй ажиллаж байжээ. Тухайлбал 1924 оны 3 дугаар сард Богд Хан уулын аймагт нутгийн захиргааны ардчилсан өөрчлөлт хийх төлөөний түшмэлээр ажиллан хүн, ам, хөрөнгө малын тоог үнэн бүрэн гаргах ажлыг зохион байгуулжээ. 1925 оны 12 дугаар сард Монгол үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд гаргах ажлыг эрхлэх «мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах» Засгийн Газрын Комиссын гишүүнээр 1925 оны 12 дугаар сараас 1928 онд мөнгөний шинэчлэлт хийж дуусгах хүртэл, гаалийн хэргийг сайжруулах комиссын дарга, эдийн засгийн зөвлөлийн

тэргүүлэгч, 1929 онд феодалын хөрөнгө хураах комиссын гишүүн, 1932 оны 9-р сард аймгуудын төвийг суурьшуулах Засгийн газрын комиссын дарга, ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг эрхлэх тусгай комиссын дарга, хууль дүрмийн хэл найрлагыг хянан шалгах комиссын дарга, 1936 онд БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх хууль тогтоолын гүйцэтгэлийг шалган хянах комиссын орлогч даргаар тус тус томилогдон нам, засгийн даалгаврыг биелүүлж байжээ. Мөн үндсэн ажлын зэрэгцээ санхүүгийн сургуульд багшилдаг байв.

МАХН-ын III, VI—IX их хурлаас Намын Төв Хорооны гишүүн, Улаанбаатар хотын Намын Хянан Байцаах Төв Комиссын гишүүн, 1926—1928, 1937—1939 онд МАХН-ын Намын Төв Хорооны Тэргүүлэгчээр, 1925—1939 онд БНМАУ-ын Бага Хурлын гишүүнээр тус тус сонгогдож байв.

С. Довчин улсын сан хөмрөгийг хэмнэж санхүүг арвижуулан шинэ эдийн засгийг байгуулж бэхжүүлэх, хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсролыг нэмэгдүүлэхэд чиглэсэн «Албан татварын компанийг өргөнөөр явуулъя» (Үнэн. 1931. №122), «Улсын албан татварын хуулийг гүйцэтгэх ба намын байгууллагуудын үүрэг» (Үнэн. 1934. 9. 7), «Октябрийн хувьсгалын 17 жилийн ой ба улсын санхүүгийн үүрэг зорилго» (Үнэн. 1934. 11. 9), «Монгол банкны 10 жилийн ой» (Ардын үндэсний эрх) 1934. №60. «Жас нарын хөрөнгийг хураах, улсын албан татварын хуулийг зөвөөр нийлүүлэхийг анхаарах» (Үндэсний эрх сонин. 1935. 4. 25), «Дээд ангийн ба ихээхэн орлого бүхий лам нараас хураах албан татварын тухай» (Үнэн. 1936. 5. 5.) зэрэг шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлж, хөдөлмөрчдийн эдийн засгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн онол практикийн дөч гаруй өгүүлэл бичиж нийтлүүлсэн юм. Тэдгээр нь улс орны эдийн засгийг хөгжүүлж, хувьсгалын ардчилсан зорилт, намын шинэ эргэлтийн бодлогыг хэрэгжүүлэх, нам засгийн бодлогыг тайлбарлаж байв.

С. Довчингийн гавьяа зүтгэлийг үнэлж Цэргийн Яаманд түшмэл байхад нь Олноогийн 8 дугаар онд Богд хаанаас дэд зэрэг, улаан жинс шагнажээ. Ардын хувьсгалын 10, 15 жилийн ойгоор Аж үйлдвэрийн гавьяаны улаан тугийн нэгдүгээр зэргийн одон, Алтан гадас одонгоор тус тус шагнажээ.

С. Довчин нам, захиргааны ямар нэг зэмлэл шийтгэл хүлээж байгаагүй. Намын дотор гарч байсан барууны хэлбэрэл, «зүүний» нугалаа гэгчид оролцож байсан гэх зэргээр шүүмжлэгдэж байгаагүй төрийн голч нуруутай төвшин хүн байжээ. Энэ нь С. Довчин аль ч талд ордоггүй ая тал засагч, төвийг сахин бөөрөнхийлөгч байв уу гэвэл тийм биш юм. Төрийн нуруу түвшин бол замын нугалаа яахав гэдэгчлэн улс төрийн голч нуруутай байсных ажээ. Ийм байдал С. Довчингийн бүхий л үйл ажиллагаан дээр ажиглагддаг.

Ахмад зүтгэлтэн Чисрэнгийн Найдан Санжийн Довчингийн тухай «Нэхэн дурсах нь» гэсэн дурсамж 1989 онд бичиж Нийгмийн ухааны институтэд өгсөн юм. Түүнд: «С. Довчин бол ардын төрийн өмнө халуун итгэл өгч, нарийн төвөгтэй хүнд чухал үүрэг хүлээлгэхэд тохирох шударга хүн гэж үнэлэгдсэн юм.. Довчин даруу төлөв, шударга үнэнч их махруу зүтгэлтэй, орос хэлтэй, ажлын чадвараар гайхагдаж олны бахархлыг төрүүлж байсны зах зухыг би ч мэднэ. Ямар ч хүнтэй эн тэгш харилцаж хэвшсэн, холч ухаан, шинэлэг хараа сайтай хүн байв¹». Монгол улсын эдийн засаг, сан хөрөнгө нимгэн болсон үед түүнийг өсгөн бэхжүүлэхэд Довчингийн оруулсан хувь хандив асар их гэдгийг хэн хүнгүй мэдэх билээ «Би тийм том хүнийг үнэлэн цэгнэхэд мэдлэг мөхөсдөнө. Харин ахмадууд хэвлэл архив л тунгаан өгүүлнэ»² гэжээ. С. Довчин бол үнэхээр Монгол эх орныхоо төлөө оюун билгээ зориулсан хүн байсныг харуулах арвин баялаг материал манай архивын сан хөмрөгт бий. С. Довчингийн удирдлагад ажиллан, ажил байдлы нь Янжив, Дамбаринчин, Өлзийт, Түмэн, Дамдин, Намжилжав, Цэвэг, Т. Дамдинсүрэн, Лувсанцэдэв, Гүнсэн нар сайн мэдэх ёстой. С. Довчин 1933 онд Морин өртөөний нүсэр хүнд албыг цомтгон хөнгөвчлөх тухай хуулийн төсөл зохиосныг Засгийн газраас сайшаан баталсныг би мэднэ «Довчин гуай хуучирддаггүй хуультай байхыг бид хүсэх ёстой гэж хэлсэн нь санаанаас гардаггүй юм. Ер нь Довчин гуай тухайн үедээ эдийн засгийн бодлого, хууль эрхийн их мэдлэгтэй, улсыг удирдах шинэ соргог санаа

1 Ч. Найдангийн дуртгал.

2. Мөн тэнд

бодлыг их эрж хайдаг»¹ байжээ. «Би 1940—1949 онд Өвөрхангай аймгийн шүүхийн даргаар ажиллаж байхдаа тус аймгийн 164 багийн 162-т нь очиж явлаа. Тэр аймгаас төрж бойжсон Довчин, Гэндэн, Түшигцоодол, Даншийцоодол, Чойдогсүрэн, Сэнгэдорж, Яндаг, Чойдог, Эрдэнэ зэрэг өдий төдий сэхээтэн, энгийн малчид, санваартангууд гүтгэлгээр амь эрсэдсэн бөгөөд тэдний гэр бүл, үр угсаа, төрөл садангийн хүмүүс санаснаа ярихыг хүсэвч «урьдаар донгодсон хөхөөний хошуу хөлдөнө» гэгчээр айцгаадаг байв. Ашгүй Сталинизмын гэмт явдлыг хянан шүүх, түүний хор уршгийг онгилон илчилсний ачаар бид бүхэн, үнэнийг хэлэх, бичих, хүн ёсны эрхээ эдлэх болов»² гэжээ.

Түүнчлэн С. Довчингийн удирдлагад ажиллаж байсан Г. Дугар, О. Намнандорж, С. Лувсан нар «С. Довчин бол бичиг үсгийн их чадалтай, ажилд идэвх зүтгэлтэй, бусдыг шахаж шаардан юм сургахын төлөө их мэрийдэг, доод хүмүүсийн эрэлт хүсэлтийг хөнгөн шуурхай хүлээж авдаг, зан харилцаа сайхантай, санхүүгийн ажилд их дадлагатай хүн байсан юм» гэж санал нэгтэй өгүүлжээ. Дурдсан хүмүүсийн яриа болон бусад зүйлээс үзвэл С. Довчин нь даруу төлөв зан харилцаатай, нөхөддөө халамжтай олон түмэнд их нэр хүндтэй, хариуцсан ажлынхаа мэдлэг боловсролыг төгс эзэмшсэн хүн байсан нь тодорхой байна. Ардын хувьсгалын 16 жилийн ойд зориулан нам, засгийн «Үнэн» сонинд нийтэлсэн С. Довчингийн товч намтарт: «Нөхөр Довчин бол 11-р (1921) оноос эхлэн энэ 16 жил улсын хүнд чухал үүрэг тушаалуудыг удаа дараа итгэмжлэгдэн хүлээж ардын хувьсгал ба улс төрийн хэрэг ажилд үнэн шударгаар чармайн зүтгэсээр бүхийн дээр нэн чухал тус улсын санхүүгийн хэрэгт онцоор чармайн зүтгэж, улс орны эдийн засаг, аж ахуйг хөгжүүлэх хэрэгт үлэмжхэн тусыг бүтээж ирсэн юм»³. Нөхөр Довчин нь «Манай улсын тусгаар тогтнон хөгжих тэмцлийн үйл хэрэгт хувьсгалын жилүүдийн турш шударга үнэнчээр зүтгэж шалгарсан гавшгай нэгэн удирдагч»⁴ мөн гэж үнэлжээ.

1. Ч. Найдангийн дуртгал.

2. Мөн тэнд.

3. Үнэн. 1937. 7. 8.

4. УТТА. ф. 1. Д. 2. ХН. 599. х. 72.

ЭДИЙН ЗАСАГ, САН ХӨРӨНГИЙГ АРВИЖУУЛАХ ҮЙЛСТ

С. Довчин 1924 онд Сангийн Яамны эрхэлсэн түшмэлээр ажиллаж эхэлсэн цагаас Монгол улсын эдийн засгийг бэхжүүлэхийн төлөө хүч мэдлэг бие сэтгэлээ зориулсан юм. Тэр үеийн Монгол орны эдийн засгийн үндэс нь уламжлалт нүүдлийн мал аж ахуй, орлогын эх булаг нь мал аж ахуйн бүтээгдэхүүн, гааль татварын орлогод тулгуурлаж байв. Үндэсний мөнгөн тэмдэгт, банк зээлийн системгүй, монголын зах зээл, гадаадын худалдаачдын эрхшээлд байсны зэрэгцээ манай орны зах зээлд гадаадын мөнгөн тэмдэгтүүд ноёрхож байсан үе юм. Ийм учраас үндэсний эдийн засгийн удирдлагыг улсын гарт төвлөрүүлэхийн тулд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн худалдаа аж үйлдвэрийн банкнийг 1924 оны VI сард байгуулж; 1925 оны XII сарын 9-нөөс Монгол улсын анхны мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж, мөнгөний шинэчлэлт явуулж эхэлжээ. С. Довчин Сангийн Яамны сайдын хувиар, мөнгөний шинэчлэлт хийх Монгол улсын комиссын гишүүний хувиар, Монгол банкны ерөнхий хорооны орлогч дарга, даргын албыг 1926—1939 онд хашиж байсны хувьд банк, мөнгөний асуудлыг төр засгийн өмнө эрхлэн хариуцаж байсан юм.

Банк бол Монгол улсын шинэ эдийн засаг, зах зээлийг зохицуулан удирдаж хөгжүүлэх гол хөшүүрэг байв. Ийм учраас үндэсний банк байгуулж, түүний үйл ажиллагааг хэвшүүлж төлөвшүүлэх нь нэн чухал шаардлагатай ажил байжээ. Банкнийг байгуулахад ЗХУ-ын шинжлэх ухааны үндэстэй туршлагад түшиглэжээ. Монгол улсын Засгийн Газраас мөнгөний шинэчлэлт хийх ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссыг 1925 онд 6 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсаны нэг нь С. Довчин юм. Энэ комиссын үүрэг нь мөнгөний шинэчлэлт, эргэлт хуримтлалын асуудлыг Засгийн газрын өмнө хариуцаж байсны зэрэгцээ мөнгөний шинэчлэлтийг гаргаж байсан банкны ажилтай нягт холбоотой байсан юм. Тийм учраас комиссын зарим хурлыг банкны зөвлөлийн гишүүдтэй хамтран хийдэг байжээ.

С. Довчингийн оролцоотой боловсруулж баталсан Монгол улсын банкны анхны шинэ дүрмэнд: «Монголын хязгаарын дотор мөнгөний гүйлгээг журамтай болгох, үнийг тэгшитгэн бататгах эд боловсруулах, мал үржүүлэх, худалдаа

арилжааны зүйлийг бадруулах»¹ болно. Банкны эх мөнгө нь хоёр зуун тавин түмэн лан буюу түүнд тэнцэх таван зуун түмэн орос төгрөгөөр тогтооно гэж заажээ.

Монгол улсын мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комиссын анхдугаар хурал 1925 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр болж дор дурдсан асуудлыг хэлэлцжээ Үүнд:

— Мөнгөн гүйлгээний тухай хуулийг нийтэд гаргах

— Бие мөнгө, мөнгөн төгрөг, алт, монят, мөнгөн тэмдэгт цаасны ханшийн тухай

— Хатуу мөнгийг банкинд хуримтлуулах болон гадаадад гаргах ба оруулах тухай

— Мөнгө гуйвуулах онц эрхийн тухай

— Мөнгөний ханшийг байнга мэдээлж байх, шинэ мөнгийг гүйлгээнд гаргах зэрэг мөнгөний шинэчлэл хийхтэй холбогдсон тулгам чухал асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

Комиссын хурал маш их ажил хэрэгч байсан нь хурлын протокол болон практик үйл ажиллагаанаас тодорхой харагдаж байна. Эл комисс Монгол оронд шинэ мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж, тус орны зах зээл, худалдаанд гүйгдэж байсан гадаадын мөнгөн тэмдэгтийг шинэ мөнгөөр сольж хураах ажлыг эрхэлж байсан Монгол банкны үйл ажиллагаанд хяналт тавьж удирдан зохицуулж байв. Комиссын ажлын хүрээнд мөнгө, зээлийн төдийгүй, худалдаа, зах зээл, эрэлт хэрэгцээний асуудал ч хөндөгдөж байв. Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комиссоос 1925 оны 11 дүгээр сараас 1927 оны эцэс хүртэл хийж гүйцэтгэсэн ажил нь тодорхой бөгөөд сонирхолтой юм. Тэр үед банк мөнгө зээлийн асуудал нь Монгол орны хувьд цоо шинэ бөгөөд шинэ эдийн засаг, сан хөрөнгийг арвижуулахад нэн чухал ач холбогдолтой. Банк мөнгөний асуудлыг шинжлэх ухааны үндэстэй явуулж зөв төлөвшүүлэхээс их зүйл хамаарах учиртай байв. Уг ажил эдийн засгийн хууль зүй тогтлыг Монгол орны онцлогтой хослуулж чадсанаар ямар нэг гажуудал, зөрчил гарсангүй. Комиссоос шинэ мөнгөн тэмдэгт ба банкны үйл ажиллагааны тухай олон түмэнд дэлгэрэнгүй мэдээлж байсны зэрэгцээ холбогдох хууль, дүрмийг боловсруулан гаргаж мөрдүүлэн хэвшүүлэхэд онцгой ан-

1. НТА. ф. 4. Д. 2. ХН. 136. х. 2.

хаарч байв. Мөн үнэ мөнгөөр зохицуулах олон ажлыг төлөвшүүлжээ. Банкнаас сольсон буюу гүйлгээнд гаргасан мөнгө болон хуучин гүйлгээнд явж байгаад хураагдсан гадаадын мөнгөний тоо хэмжээг нэгтгэн комиссын хуралд сонсдог байжээ. Жишээ нь 1926 оны нэгдүгээр сарын эхээр болсон Комиссын Ү хуралд 1925 оны 12 дугаар сарын 9-нөөс эхлэн шинэ мөнгө гарснаар 1 бум, 2 түмэн мөнгөн янчаан хураагдаад байгааг мэдээлжээ. 1926 оны нэгдүгээр сарын 30-нд болсон VI хуралд Монголд гадаадаас оруулж буй бараа үнийн дүнгээрээ 20 сая орчим янчаан болно. Гурван томоохон худалдааны газрын бараа нь 3 сая, 3 бум. Үүнээс Монцинков 1 сая 3 бум, Сибгосторг 9 бум, Ноос хоршоо 1 сая 1 бум, Тэр байгууллагууд СССР-ээс 2 сая 7 бум, Хятадаас 1 сая 7 бум 3 түм 1 мянган янчаан бүгд нийлж 7 сая 7 бум 8 түм 1 мянга болж үлдэх 13 сая нь гадаадын пүүсүүдийнх байв. Хатуу мөнгөний гүйлгээг хэд хэдэн газар явуулж хөгжүүлэхийг монгол банкинд, Дорно зүгийн зах зээлд гаргахаар төлөвлөн бүхий түүхий эдийг яаравчлан гаргахыг Монцинковт тус тус зөвлөх. Монголд ажиллаж буй ЗХУ-ын худалдааны монголд оруулах барааны чанарыг сайжруулах талаар ЗХУ-ын худалдааны элчингээс онцгойлон анхаарч санаа тавихыг хүсэмжлэх, Хаалган, Манжуур, Алтанбулагийн замыг засч сайжруулахыг, зоос мөнгөний хуулийг даруй гаргаж олон нийтэд таниулахыг Засгийн газарт тавьж тус тус шийдвэрлэхээр тогтов. Зах зээлд дутагдан бүхий гадаадад оруулах барааг Монгол, Зөвлөлтийн худалдааны байгууллагуудыг хамтран хуралдуулж хянан хэлэлцүүлэхийг Монгол банкинд даалгажээ.

1926 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн байдлаар банкнаас тавьж олгосон мөнгөн тэмдэгт цаас 1196000, гаргаж зарцуулсан нь 1100000 банкны хэлтсийн мэдэлд бэлэн буй монгол төгрөг 75800, гаргаж зарцуулсан банкны тэмдэгт цаасны 100-ны 80 хувь нь цагаан мөнгөн баталгаатай, банкны бүх мөнгөн гүйлгээний гурван хувь нь монгол төгрөг, тараасан монгол төгрөг 3 бум шахам болно. Шинэ мөнгөний гаралт сард дунджаар 200000 болох бөгөөд ийм байдлаар явбал 12000000 хүртэл бэхжүүлэхэд 5 жил хэрэгтэй гэж үзжээ. Монгол улсын хэрэглэвээс зохих барааны зууны 32 хувийг Монгол, ЗХУ-ын худалдаа эзэлж, үлдсэн 68 хувийг бусад хадалдаа эзэлж байна гэжээ. Бараа ховордсоноос дүн-

сэн тамхи, боодол нь 65 мөнгөнөөс 1 янчаан 20 мөнгө, даалимбуу 2 янчаан 30 мөнгө хүрчээ. Бараа ховордох нь төгрөгийн үнийг муутгаж чадахгүй боловч саад болж магадгүй. Мөнгөн тэмдэгт цаас, зоос эрдэнийн зүйлийг гадагш гаргах, оруулах дүрмийг Засгийн газраас яаравчлан гаргах шаардлагатайг уламжлан гүйцэтгэжээ.

1925 оноос тэмдэгт цаасны баталгаанд зууны 75 хувиас дутуугүй зоос мөнгөөр гүйцэтгэж байжээ.

Монгол төгрөг гадаадад ихээр гарваас мөнгөний тэнцвэр алдагдах будлиан бүхий учир гадаадын харилцах этгээдэд Монгол банкнаас зөвшөөрөгдсөн хэмжээтэй, тогтсон ханшаар авбаас зохих учрыг хянан гүйцэтгүүлэх. Барааны хүрэлцээ, хэрэгцээг хянан үзэж, дутагдах барааг нэн яаравчлан СССР ба Хятадаас ирүүлэхээс гадна СССР-ийн Засгийн газартай харилцан Нижногородын яармагаас нэн даруй авчрахыг тохиролцон хэрэгжүүлж байв.

Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах комиссоос олон нийтэд нэн чухал хэрэгцээт барааны үнийн байдлыг хянан шинжилж, монгол банкнаас тухайн байдалд нийлүүлэн зохицуулж байх. Энэ асуудлыг комиссын хурлаар үе үе хэлэлцүүлж байх нь зүйтэй гэж үзэн ёсоор гүйцэтгэж байжээ.

Хятадын зэс мөнгийг 1927 оны III сарын 1-нээс гүйлгээнд гаргахыг хориглон зогсоож, зэс мөнгөний 500 ширхэгийг нэг төгрөгөнд тэнцүүлэн хураажээ. Мөн Монгол төгрөгийг алтан баталгаатай болгох тухай асуудлыг тавьж зөвшөөрүүлж байв.

Мөнгөний шинэчлэлт 1925—1928 он хүртэл үргэлжлэн хийгдэж дуусчээ. Мөнгөний шинэчлэл хийснээр Монголын зах зээлд тэгш эрхтэй гүйгдэж байсан гадаадын мөнгөн тэмдэгтийг дотоод зах зээлээс шахан гаргаж, үндэсний мөнгө дангаар ноёрхох болов. Нөгөө талаар Монгол орны эдийн засгийн удирдлагыг улсын гарт авч төвлөрүүлэн удирдах, санхүүгийн нэгдсэн системийг нэвтрүүлж бэхжүүлэх бололцоог хангасан нь үндэсний шинэ эдийн засгийн төлөө тэмцлийн том ололт болов.

Тэр үеийн Монгол орны дотоод улс төрийн байдлыг тогтворгүй болгож байсан нэг зүйл нь Коминтерн, ЗХУКН-аас далдуур зохион байгуулсан монгол үндэсний эх орончдыг баруунтан хэмээн шүүмжлэн зайлуулах компани юм. Баруунтныг буруутгах өргөн шүүмжлэлийн үед С. Довчин-

гийн байр суурь ямар байв гэвэл тэр хэнийг ч баруунтан гэж шүүмжилсэнгүй. Бас түүнийг буруушаан шүүмжилсэн баримт үгүй байна. Баруунтан хэмээгчдийг илрүүлэн бутцохилоо гэж зарлан тунхагласан МАХН-ын ҮII их хурал дээр С. Довчин хэлсэн үгэндээ: Захиргааны аппаратыг цомтгон арвилан хэмнэж, хэмнэсэн зүйлийг сургууль соёлын зардалд зориулах, албан татварыг боловсронгуй болгох, орлогыг нэмэгдүүлж, зарлагыг багасгах, зэрэг улс орны амьдралд чухал холбогдол бүхий хэд хэдэн чухал санал тавиад «Намын доторхи зөрөлдөөний үүсвэр шалтгааныг миний бие үүний урьд олж мэдээгүй явсны учир бол Намын Төв Хорооны Тэргүүлэгчээр сонгогдоод удаагүйгээс болсон амуй» гэжээ. С. Довчин үгийнхээ төгсгөлд архины хорын тухай архийг өргөн хэрэглэхийг хязгаарах тухай маш чухал санал тавьжээ. Үүнд: «Энэ хэр архины зүйлийг улсын онц эрх болгон худалдаалж бүхий нь шунахай худалдаачны мөлжлөгийг устгах ба багасгах арга мөнийн дээр улсын санд үлэмжхэн орлоготой боловч улсаас архины зүйл болбоос ард олонд өчүүхэн ч тусгүй байтугай, ухаан сэтгэлийг төөрөгдүүлэх, өр шир, элдэв будлианд холбогдох зэргийн туйлын хортой зүйл сааргүй мөн. Иймд архины зүйлийг зүй нь шууд цаазлан зогсооход үл болох газар үгүй мэт боловч олон улсын дотор хэрэглэсээр бүхийн дээр элдэв нууц аргаар боловсруулан гаргах болзошгүй тул үүнээс урагш үлэмжхэн хатуу мөнгийг гаргаж гадаадаас хатуу чанартай архи авчрахыг чадваас бүрмөсөн зогсоож, ядавч бага болгон, зөөлөн чанартайг нь дотооддоо боловсруулан хэрэглэх ба малын шимээс гарах архины зүйлийг хэрэглэх заншилтай болгох зүгт хандуулан явуулах бодлогыг чанартай явуулбаас зохих болбуу»¹ гэжээ. Ийнхүү ухаант мэргэд маань архины хор холбогдлын тухай эртнээс нааш анхааруулж, сургамжилж ирсний ачаар монголчууд архийг хавтгайран хэрэглэхийг цээрлэн ялангуяа эмэгтэйчүүд, лам нар, залуучууд огт хэрэглэж байгаагүй уламжлалтай билээ. Гэтэл сүүлийн үед архидан согтуурах явдал хавтгайрч буй нь даанч харамсалтай байна.

Намын Төв Хорооны Тэргүүлэгч, төрийн сайд хүн баруунтныг шүүмжлээгүй нь сонирхолтой боловч С. Довчин аливаа асуудалд ухаалаг ханддаг улс төрийн төвшин нуруу-

1. МАХН-ын ҮII их хурал УБ. 1980, х. 154—157.

тай байсны жишээ юм. С. Довчин дуугүй сууж цаг нөгцөөх юмуу эсвэл бусдыг аялдан дагаж цэцэрхэгч байсангүй. Харин асуудалд хамгийн ажил хэрэгч хандаж дутагдлыг илрүүлж ажил сайжруулахад чиглэсэн үнэтэй чухал санал шүүмжлэл тавьж байсныг архивын баримт нотолж байна.

Үндэсний аж үйлдвэр байгаагүй тухайн нөхцөлд улсын орлогын эх булгийн нэг нь татварын орлого байв. Төр засгаас албан татварын бодлогыг ард түмний аж амьдралд дарамт учруулахгүйгээр явуулах зорилт тавьж байв.

С. Довчинг Сангийн Яамны Сайдаар ажиллаж байсан хорь гучаад онд тус улсын санхүү зээл, бүртгэл, тайлан тооцооны системийг бий болгох үндэсний мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж мөнгөний шинэчлэлт хийсэн, улс хоршоолол, хувийн өмчинд санхүүгийн хяналт тогтоох, улсын даатгалын албыг цоо шинээр байгуулах зэрэг ажлыг удирдан зохион байгуулжээ. Тухайлбал, 1926 оноос бүртгэлийн материал ордрийн системийг нэвтрүүлж, санхүүгийн байгууллага, төсөвт газруудын улирал, жилийн тайлан балансыг авч нэгтгэх журмыг хэвшүүлжээ. Худалдаа, газар тариалан, ард олны хөрөнгө малаас хураах ашгийн татвар, сүм хийд, лам нар, цэргийн татвар ашгаас хувь хураах татвар зэрэг болно. 1934 оноос улсын даатгалын албыг байгуулжээ. Мөн үед улсын төсвийн орлого, зарлага их өссөн байна. Улсын орлого 1927 онд 15724,6 мянган төгрөг байсан бол 1937 онд 69363,0 мянган төгрөг болж 4,4 дахин, зарлага 1927 онд 15165,5 мянган төгрөг байсан бол 1937 онд 65401,5 мянган төгрөг болж 4,3 дахин өсчээ. Энэ мэтээр тус улсын санхүү эдийн засаг, тайлан бүртгэлийн ажлыг шинжлэх ухааны үндэстэй удирдан хөтлөх шинэ системийг нэвтрүүлж, үндэсний шинэ эдийн засгийн хөгжилд чухал алхам хийсэн үе байв. 1925 онд хуралдсан Улсын II Их Хурлын шийдвэрийг үндэслэн нэгдсэн албан татварын (НАТ) хууль боловсруулахыг Сангийн Яаманд даалгажээ. Тэр шийдвэр ёсоор нэгдсэн албан татварын дүрмийг С. Довчингийн удирдлагаар боловсруулсныг 1926 онд Улсын Бага Хурлаас анх удаа батлан гаргажээ. Уг дүрмийг МАХН-ын V Их Хурлаар хэлэлцээд орон нутгийн захиргаадын эрхэлж байсан хуучин журмыг өөрчлөн «орлогын үндсэн зүйлийг баттайгаар тогтоохыг чухал болгож зарласныг чангаар арвилан, аливаа газар хэтрүүлэх гэмийг устгаж, татварыг өсгөн татварлаж

алба татах, цагийг тогтмол болгох ба бүх аймаг хошууны албыг эрхгүй бараглан төлөвлөж, нийгэм тэгшээр хувааж орон нутгийн албаны газар түүгээр эрхлэн аливаа татварлах эрхийг устгасугай»¹ гэжээ.

Нэгдсэн албан татварын дүрмийг (НАТ) улсын III их хурлаас батлан сайшааж 1927 оноос мөрдөхөөр заажээ.

Уг дүрмэнд албан татварын бодлогыг Засгийн Газраас эрхлэн мэдэж байхаар тогтоожээ. НАТ нь худалдаа, мал аж ахуй, газар тариалангийн татварын хуулиас бүрдэж байв. НАТ-ын хууль нь өсгөн нэмэгдүүлж татварыг тогтоон түүний дээд хэмжээг 2.5 хувиас хэтрүүлэхгүй байхаар заав. Хуулинд 5 хүртэл бодтойг татвараас чөлөөлж, 6—10 бодтой олон ам бүлтэй аж ахуйтны 3 бодыг, 11—20 бодтой бол 2 бодыг чөлөөлөх, 21—30 бодтой аж ахуйд ноогдох үндсэн татварыг нь оноох, 51-ээс дээш бол үндсэн ноогдлыг нь 3—120 хүртэл өсгөн нэмэгдүүлэхээр тогтоожээ. (1 бод нь 7 хонь, 14 ямаа байв) Өртөөний морь, улсын үйлдвэр аж ахуйн газруудын мал сүрэг, үр шим сайтай монгол үүлдрийн болон сайн угсааны малыг татвараас чөлөөлжээ. Татварын хуулиар орон нутгийн захиргаад онц шаардлага гарвал нийт аж ахуйтны хөрөнгийн 10 хувьд таацуулан нэг удаа татвар хураах эрхийг олгожээ. Мөн өртөөний алба гүйцэтгэгчийг чөлөөлөх болов. Нэгдсэн албан татварын хуулийг нийтээр хэлэлцүүлэх явцад аж ахуйтны үл хөдлөх хөрөнгөнөөс татвар хураах нь зүйтэй гэсэн МАН-ын 103 дугаар үүрийн бүх гишүүдийн хурлын саналыг үндэс болгон үл хөдлөх хөрөнгөөс татвар хураах зааврыг гаргав. Түүнд үл хөдлөх хөрөнгийн тогтвортой үнэ 450 төгрөгөөр, 150 төгрөг тутмыг нэг бодод таацуулан татвар ноогдуулах болов. Нэгдсэн албан татварын хууль ёсоор 1927 онд 5,5 сая төгрөгийн татвар хураажээ. Энэ нь бод нэг бүрт 1 төгрөг 20 мөнгөний татвар ноогдуулжээ. Ийнхүү анх удаа явуулсан албан татварын хуулийн заалт болон амьдрал дээр хэрхэн биелж буй байдлаас үндэслэн 1928 онд явуулах татварын зааврыг шинэчлэн боловсруулан 5,7 сая төгрөгийн татвар хураажээ. 1929 оны Ү сард хуралдсан Төв Хорооны бүгд хурал албан татварын хэргийг шинэчлэн явуулах асуудлыг хэлэлцэхдээ урьд бодоор ноогдуулж байсныг өөрчилж, мал хөрөнгийг үнэлэн зохиосон хувь гэдэг шинэ нэгжээр явуулахаар тог-

1. НТА. ф. 1. Д. 3. ХН. 1. х. 5.

тоожээ. 20 хувь хүртэл хөрөнгөтэй аж ахуйг албан татвараас бүрэн хэлтрүүлж, 21-ээс 50 хүртэлийг хөнгөлөлт үзүүлэх, 51-ээс 100 хувьтанд тогтоосон ёсоор татвар ноогдуулах, 101-ээс дээш хувьтайд нь нэмэгдүүлэх татвар ноогдуулах болов. 1930 оноос НАТ-ын нэг хувьд нэг төргөг 10 мөнгө байсныг хөнгөлөн, 100 хүртлэх хувьтай аж ахуйтны ноогдлыг 20 хувиар хорогдуулжээ. 101-ээс дээш хувьтай бол өсгөн нэмэгдүүлэхээр тогтоожээ. Хөнгөвчилсөн байдлаар 1930 онд 10 сая төгрөгийн татвар хураажээ. НАТ-ын хууль нь ардын аж ахуйтны хөдлөх ба үл хөдлөх хөрөнгө болон өрхийн орлогоос татвар хураах болов. 1—2 ам бүлтэй өрхийн орлого нь 100 төгрөг, 3—4 ам бүлтэй өрхийн орлого нь 150 төгрөгөөс хэтрэхгүй бол тус тус НАТ-аас чөлөөлж байв.

1926 оноос БНМАУ-ын Сангийн Яам, банкнаас аж үйлдвэрийн газрыг байгуулах, түүхий эд, газар дэлхийн баялгийг боловсруулж ашиглах, ялангуяа мал аж ахуй, газар тариаланг хөгжүүлэхийн тулд малчид, сангийн аж ахуйд мөнгөн зээл олгох болсон нь үр ашгаа өгчээ.

НАТ-ын бодлогыг улсын төсвийн орлогыг арвижуулах, хүн амын амьдралыг сайжруулах бодлоготой нягт уялдуулан татварын хуулийг боловсронгуй болгож жил жилийн улсын их, бага хурлын чуулганаар хэлэлцэн баталж байв. Иймээс НАТ нь ард иргэдэд хүнд дарамт болохгүй байжээ. 1926 оны 10 дугаар сараас гадаадын худалдаачдын гүйлгээний орлогоос татвар хураах болов. Экспорт, импортын бараанаас хураах ашгийн татварыг бас нэмжээ. Албан татварын болон өртөөний хууль, энгийн худалдааны тухай тогтоол зэрэг нь зарц ядуучуудын амьдралын баталгааг хангахад их анхаарч байжээ. Тиймээс малгүй үгээгүйчүүдийн зарим нь бие даах чадалтай болж, зарим нь ажилчин болж албан хаагчдын эгнээнд шилжиж амьдралын өөр эх булаг олж авснаар ядуучуудын тоо цөөрч байв. Харин дунд аж ахуйтны хувийн жин 34—57,8 хувь болтол өсчээ.

Монголчуудын эрэлт хэрэгцээг хангахад зориулан өргөн хэрэгцээний зарим барааг тусгай захиалгаар ЗХУ-д үйлдвэрлэн, Монголд нийлүүлэх, монголоос ЗХУ-д төлбөл зохих өрийг анхааран үзэж 1934 онд хүчингүй болгожээ.

Ардын хувьсгалын ойг тохиолдуулан түүхт хүмүүс, төрийн зүтгэлтний тухай, тэдний эх орон, ард түмний өмнө байгуулсан гавьяа зүтгэлийг хэвлэн нийтэлж, олон түмэнд

сурталчлан таниулдаг уламжлал ёсоор хувьсгалын 16 жилийн ой 1937 оны YII сарын 8-ны өдрийн «Үнэн» сонинд С. Довчингийн тухай том өгүүлэл нийтэлжээ. Түүнд: С. Довчин нь «Бага наснаасаа эхлэн аймаг хошууны ба улсын албанаа зүтгэж агсан зэрэг түүх туршлагатай болохоос гадна ялангуяа II (1921) оноос эхлэн 16 жил улсын хүнд үүрэг тушаалуудыг удаа дараа итгэмжлэгдэн хүлээж тус ардын хувьсгалын ба улс төрийн хэрэг ажилд үнэн шударгаар чармайн зүтгэсээр бүхийн дээр нэн чухал тус улсын санхүүгийн хэрэгт онцоор чармайн зүтгэж улс орны эдийн засаг, аж ахуйг хөгжүүлэх хэрэгт үлэмжхэн тусыг бүтээж ирсэн учир¹ «Төрийн дээд» шагнал одонгуудаар шагнажээ. С. Довчин бол «Манай улсын тусгаар тогтнон хөгжих тэмцлийн үйл хэрэгт хувьсгалын жилүүдийн турш шударга үнэнчээр зүтгэх шалгарсан нэгэн удирдагч»² мөн гэж бичжээ.

ШИНЭ ЭРГЭЛТ БА ЭДИЙН ЗАСГИЙН АСУУДАЛ

МАХН-ын Төв Хорооны Онц III бүгд хурлаас гаргасан шинэ эргэлтийн бодлого нь Монгол орныг нийгэм, эдийн засгийн хямралаас гаргах, ард олны амьдралыг сайжруулж, хувийн сонирхолыг нь дээшлүүлэхэд бүрэн чиглэж байв. Шинэ эргэлтийн үзэл санааг тууштай хэрэгжүүлэгчийн нэг нь С. Довчин байсан юм. Ард олны амьдралыг дээшлүүлж бүтээлч идэвхийг өрнүүлсэн шинэ эргэлтийн арга хэмжээний нэг нь албан татварын шинэ хууль юм. Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1933 оны YI сарын 20-ны өдрийн хуралд мал аж ахуйн албан татварын шинэ хуулийн тухай Сангийн Яамны сайд Довчин илтгэл тавьжээ. Түүнд гаргасан тогтоолд: мал аж ахуйн албан татварын шинэ хууль нь намын Төв Хорооны онц III бүгд хурал, Улсын XUII онц бага хурлын тогтоол шийдвэртэй нийлэмжтэй болсныг тэмдэглээд, засгийн газраас ард түмний албан татварыг хөнгөтгөж байгаа бодлого нь тэдний хувь хувийн мал ахуйгаа хөгжүүлж амьдралыг нь сайжруулахад бүрэн чиглэж байгаагийн бодит баримт болов. Тус хурлаас албан татварын шинэ хуулийг олон түмэнд өргөн сурталчлахыг хэвлэл мэдээллийн байгууллагуудад даалгажээ³.

1. «Үнэн» сонин. 1937. 7. 8. №26

2. Мөн тэнд

3. НТА. ф. 1. Д. 4. ХН. 171. х. 112.

Албан татварын шинэ хууль үйлчилж эхэлснээр 1933 онд ардын аж ахуйтны бүх өрхийн 55,3 хувийг албан татвараас чөлөөлж, татвар төлбөл зохих өрхийн 37 хувьд янз бүрийн хөнгөлөлт үзүүлжээ. 1934 оны VI сараас мал аж ахуйн албан татварын өсгөн нэмэгдүүлэх зарчмыг өөрчилж, бэлэн байгаа малаас хураах болсон бөгөөд малын арчилгаа, маллагааг сайжруулах малчдад албан татварын хөнгөлөлт үзүүлэн, тэдний гар урлал, ан агнуурын орлогоос татвар авахыг болиулжээ. Ардын аж ахуйтнаас гэрээгээр улсад худалдах малын үнийг 25 хувь, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дунджаар 20 хувиар нэмэгдүүлэв. Ардуудаас мал аж ахуйгаа өсгөхөд нь зориулж урт, богино хугацаатай зээл олгох, байгалийн гамшигтай тэмцэхэд нь тусламж үзүүлэх, мал эмнэлгийг хөгжүүлэх зэрэг арга хэмжээг улсаас авчээ. 1932 оны XI сард Сайд нарын Зөвлөлөөс энгийн худалдааны тухай тогтоол гаргаж, хөрөнгө чинээний байдлыг харгалзахгүйгээр хувийн худалдаа хийх, худалдааны пүүс, нөхөрлөл, энгийн хүмүүст зуучлахыг зөвшөөрч улс хоршооллын байгууллагуудаас бөөний болон жижиглэнгийн үнээр бараа авах, банкнаас мөнгө зээлэх эрхийг тэдэнд олгож, хураах татварын хэмжээг багасгажээ.

1932 оны X сард Сайд нарын Зөвлөлөөс баталсан хувийн аж ахуйтнаас хөлсний хүч хэрэглэх дүрмийн дагуу хөлслөгч нь хөлслүүлэгчийг ажлын багаж хэрэгслээр хангаж, аж амьдралаа дээшлүүлэх бололцоо олгох, хөлслүүлэгч нь үнэнч шударгаар хөдөлмөрлөж, малын тоо толгой, ашигшим, тариалангийн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд нь хөлслөгчид туслах зэрэг үүргийг харилцан хүлээж, ажиллах хугацаа, авах хөлсийг тохиролцсон гэрээ байгуулах болжээ. Газар тариалан хувиараа эрхлэгчдийн тоо өсч хүн амын уламжлалт хэрэгцээний арвайн гурил, болсон будаа үйлдвэрлэх, үр тариа, хүнсний ногоог тарьж, зах зээлд худалдах явдал нэлээд нэмэгдэв. Энэ бүхэн нь улс орны эдийн засгийг сэргээн хөгжүүлж, ард түмний амьдралыг сайжруулахад бүрэн чиглэж байв.

1934 онд хуралдсан Улсын ХVIII бага хурлаас «улсын орлого зарлага, албан татварын орлого ба нийт санхүүгийн байдлын тухай Сангийн Яамны сайд С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоолд:

Нэг. Улсын ХVIII Бага Хурлаас хойш улсын санхүүг ба-

татгах талаар явуулсан бодлого зүйтэй болохыг батлахын хамт түүний амжилт нь:

1. Улсын орлого зарлагын нийт хэмжээг тус улсын аж ахуйн хөгжилт санхүүгийн хэр чадалд зохицуулан тохируулах, засаг захиргааны ба бусад үргүй зардлыг эрс шийдвэртэй хасч ард түмнийг татварын үүргийг ихээхэн хөнгөтгөж, хялбар дөхөм болгожээ. Бас ардын хувийн аж ахуйтнаас аж ахуйг хөгжүүлэхэд тустай санаачлагуудыг гаргасан хүмүүст татварын хөнгөлөлтийг улам өргөтгөсний үрээр ардын ахуйтны ихэнх нь хөнгөлөлт үзсэн ба хэтэрсэн билээ.

2. Ардын аж ахуйтанд олгох зээллэгийн журмыг шинэтгэн явуулсан нь түүний сахилга батыг чангатгахын хамт улсын ба кооперативын байгууллагаас орлогоороо зарлагаа нөхөх чиглэлийг хүчтэй болгох, худалдааны эргэлтийг хурдавчлах, ардын хувийн аж ахуйтан, энгийн худалдаа, гар үйлдвэрүүдийн хөгжилд ихээхэн тусыг үзүүлж буй амуй.

Хоёр. Засгийн газраас цаашид анхаарах чухал зүйлийг дурдвас:

1934 оны улсын орлого зарлагын хяналтын тооноос үзвэл орлого нэлээд нэмэгдсэний учир нь албан татварын хэмжээ нэмэгдсэнээс бус тус улсын үйлдвэрлэх хүчин өсч хөгжсөн, барааны гүйлгээ өссөнийх билээ. 1934 оны төлөвлөсөн зарлага ч хасагдах ёстой. Улсын бүх албан газар, байгууллагын мэдэлд улсаас олгосон хөрөнгийг хэрхэн хэрэглэж буйг үзэхдээ зөвхөн зардлын хэмжээгээр бус харин эл хөрөнгийг улсад ямар ашиг тустайгаар хэрэглэж, арвилан хэмнэж чадсан, эссэн зэргээр үнэлвээс зохино. Улсын XVIII Бага Хурлаас 1934 оны улсын орлого, зарлагын хэмжээг 27606640 төгрөгөөр баталж АСНЗ-д даалгах нь:

а). Урьд баталсан улсын орлого зарлагын төсөв түүнээс сая төгрөгийг хасч гүйцэтгүүлсүгэй.

б). Зарлагыг хасахын хамт орлогоос 200 мянган төгрөгийг дамжуулан хураах орлогоос 600 мянган, энгийн худалдааны татварын орлогоос 200 мянган төгрөгийг тус тус хасваас зохино.

в). Яам, газрын орон тоог хянан үзэж хэмнэх

г). Орлого зарлагын сахилгыг хатуу мөрдөх

д). Улсын хөрөнгийг хайхрамжгүй зарцуулж үрэгдүүлэхийг устгаваас зохино.

е). Касс хийгээд тайлан, дансны сахилга батыг зөрчигчдөд хуулийн хариуцлага хүлээлгэвэл зохино.

ё). 1933 оны албан татварын хуулийг 1934 онд хэвээр мөрдөхөөр Сайд нарын Зөвлөлийн тогтоосныг сайшаасугай.

Гурав. Ардын хувийн аж ахуйтны ба энгийн худалдаанд олгох зээллэгийг өргөтгөн бэхжүүлэх, улсын худалдаа хоршооллын аж ахуйн орлого, зарлагыг нөхөн гүйцэтгүүлэх хийгээд мөнгөн гүйлгээг сайжруулах нь зүйтэй гэж үзсүгэй¹ гэжээ.

С. Довчин МАХН-ын IX их хурал дээр хэлэхдээ: Намын «Шинэ эргэлтийн бодлого нь тус улсын тусгаар тогтнох явдлыг тасралтгүй бэхжүүлэх хэрэгт туйлын гүнзгий холбогдсон бодлого болох ба түүний үр бүтээл нь аль хэр амжилттай дүн гаргаж өссөн болох нь бидэнд тодорхой мэдэгдэж байна»² Шинэ эргэлтээс хойш мал аж ахуй ба ардын хувийн аж ахуйг хөгжүүлэх талаар олон түмэн ардын идэвх санаачлагыг дээшлүүлж чадсан юм³ гэжээ.

С. Довчин улс орны эдийн засгийн асуудлыг нам, засгийн өмнө хариуцаж байсны хувьд улсын төсөв, орлого, зарлага, банк, санхүү зээлийг хөгжүүлэх, албан татварыг боловсронгуй болгож сүм хийд, лам нарын эдийн засгийн хүчин чадлыг бууруулан хязгаарлахад чиглэсэн олон хууль дүрмийг боловсруулан гаргахад биечлэн оролцож, тэдгээрийг хэрэгжүүлэхийн төлөө идэвхтэй тэмцэж байсан юм.

«Үр ашиггүй зардлыг эрс тэсээр хорогдуулан өөрчилж, ард түмний алба татварын үүргийг хөнгөвчлөх арга хэмжээ авсаар ирсэн нь тус улсын санхүүгийн байдал нэлээд батжил сайжралыг олж чадах амжилтын дүнтэй байна. Хэдий тийм боловч бидний өмнө санхүүгийн хатуу сахилга батыг үл хайхрах ба ер арвилан хэмнэх ёсыг бүрдүүлэн явуулж сураагүй их дутагдал байна. Энэхүү арвилан хэмнэх хэмээгч болбаас бидний мэт бага буурай улс байтугай ямар нэгэн боловсон хүчирхэг улсад ч туйлын чухлаар үзэж, эрхбиш биелүүлэн явуулдаг ёстой ажгуу»⁴ гэж Довчин бичжээ.

Хорь гучаад оны нам, засгийн бодлогын нэн чухал хэсэг нь сүм хийд, лам нарын эдийн засгийн байр суурийг устгах зорилгоор алба татварын талаар хавчин хязгаарлахын зэ-

1. БНМАУ-ын XVIII бага хурлын тогтоол УБ. 1934 он. х. 159—166.

2. МАХН-ын IX их хурал УБ. 1984. 318 дахь тал.

3. Мөн зохиол 319 дэх тал.

4. МАХН-ын IX их хурал. УБ. 1934. 321 дэх тал

рэгцээ хар болсон лам нарыг нийгмийн тустай хөдөлмөрт оруулахад их анхаарч байв.

МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1935 оны XI сарын 26-ны өдрийн 40 дүгээр хуралд лам нараас хураах албан татварын асуудлаар С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоолд сонгуулийн эрхтэй лам нараас цэргийн татвар авах, залуу лам нарыг хар болгож ажилд оруулан бичиг үсэг сургах, засгийн газрын төлөөлөгч суугаагүй аймгуудад төлөөлөгч суулгах шашны зөвлөл байгуулах, цэргийн насны залуу лам нарыг үйлдвэрт түр ажиллуулах, соёл, хүмүүжлийн бусад ажил зохиох, 18 нас хүрснийг өөрийн нь хүсэлтээр хар болгох нь зүйтэй гэжээ.

1937 оны 3 дугаар сарын 10-нд С. Довчингоос Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга нарт бичсэн нь: «1936 онд АСНЗ ба Намын Төв Хорооноос гаргасан тогтоол ёсоор улсаас 500,000 төгрөгийн хөрөнгө тусгайлан гаргаж сүм хийдээс бүрмөсөн ангижирч хөдөө аж ахуй байгуулах лам нарт урт хугацааны зээллэг олгоход зориулан, мөн энэ тухай хэрхэн гүйцэтгэх заавар зарлалыг гаргаж явуулсан ба мөнхүү зээллэгийн хөрөнгөнөөс аль аймагт хичнээн төгрөгийн зээл олгохыг улиралд тус бүрт хэмжээ тогтоон хуваарилаж, тухай бүр явуулсаар ирсэн бөлгөө. 1937 оны I дүсарын 1-ний мэдээгээр Дорноговиос бусад 11 аймаг, Улаанбаатар хотын зээллэг авсан лам нар 204, олгосон төгрөг 114400² болно гэжээ.

1937 оны V сарын 27-нд Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 45 дугаар хуралд С. Довчин тавьсан илтгэлдээ: Сангийн Яам, Монгол банкнаас лам хүүхдүүдийг хар болгон санхүүгийн техникумын сургуульд бэлтгэл анги нээж 15-аас дээш насны хүүхдийг элсүүлэн гурван жил суралцуулахаар зардалд 190000 төгрөг төсөвлөн гаргажээ³. Тэрхүү бэлтгэл ангийн хичээлд ерөнхий эрдэм голлохын зэрэгцээ мэргэжил хөдөлмөрийн дадлага олгох, үүнд: зураг, урлал, сийлбэр, мужаан, оёдол, хатгамал, хээ, угалз зэргийг зааж сургах болно гэж тэмдэглэжээ. Уг сургуулийг эхлүүлэн хичээллүүлж буй явцын тухай сайд С. Довчингоос 1937 оны VII сарын 7-нд мэдээлсэн байна.

1. НТА. ф. 1. Д. 5. ХН. 101. х. 67.

2. НТА. Ф. 4. Д. 6, ХН 123 х,

3. НТА. ф. 4. Д. 6. ХН. 123. х. 33.

С. Довчингийн бичсэн «Ардын хөрөнгө болох нэг мөнгийг үрэгдүүлэхгүйгээр арвилан хэмнэе» гэдэг том өгүүлэл «Үнэн» сонинд 1936 оны IY сарын 22-нд нийтлэгдсэн юм. Түүнд: «Тус улсын тусгаар тогтнох эрх чөлөөт байдал улмаар батжиж дэвшин хөгжихийн үндсэн тулгуур нь даруй эдийн засаг аж ахуй санхүүгийн явдал мөн бөгөөд энэхүү улс ардын хөрөнгө болох нэг мөнгийг ч дэмий үрэгдүүлэхгүйгээр арвилан хэмнэж үр ашигтай зүйлд зөв хэрэглэх нь улс төрийн хөгжин батжих их зорилгыг хангаж»¹ байдаг. 1931 оны Y сарын 2-ны өдрийн МАХН-ын Төв Хороо, НХБТК-ын Тэргүүлэгчдийн хавсарсан хуралд: хөдөө аж ахуйн нэгдсэн албан татварын тухай С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоолд «Тус орны хөгжил нь хөрөнгөтний бус нийгэм журмын замын төлөө тэмцэх... хөрөнгөтөн этгээдийн мөлжимтгий эрмэлзлэлийг хавчин хязгаарлах, шинэ хамтын маягтай аж ахуй хийгээд хоршооллыг байгуулан бэхжүүлэх зэрэг монголын хувьсгалын гүйцэтгэх зорилгыг биелүүлэхэд хөдөө аж ахуйн нэгдсэн албан татвар даруй тохирч»² байгаа юм.

БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдын орлогч, Сангийн яамны сайд, Улсын банкны ерөнхий хорооны дарга С. Довчин 1933 оны 12 дугаар сард ЗХУ-д ажлын айлчлалаар очиж мөн сарын 22-нд В. Моловтой, 1934 оны нэгдүгээр сарын 11-нд И. В. Сталинтай уулзжээ. Уулзалтад МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Б. Элдэв-Очир, БНМАУ-аас ЗХУ-д суугаа элчин Г. Самбуу нар байв. Уулзалт яриа Монгол, Зөвлөлтийн худалдаа, эдийн засгийн харилцааг өргөтгөж, өр төлбөрийг нааштай шийдэхэд их ач холбогдолтой болов. С. Довчин Монгол, Зөвлөлтийн харилцааг бэхжүүлэхэд худалдаа, эдийн засгийн асуудлыг өргөтгөх нь туйлийн их ач холбогдолтой гэж тэмдэглээд монголд ажиллаж буй Орос мэргэжилтэнд тавих шаардлагыг өндөржүүлэх, Монгол дахь Орос иргэдийг тавин хувь хүртэл цөөлөх, нийгмийн тустай хөдөлмөрт үл оролцдог лам нарын асуудлын тухай санал тавьжээ. И. В. Сталинаас лам нарын эсрэг тэмцлийг хүчтэй болгохдоо ихээхэн болгоомжтой аажим ухаалаг бодлого явуулах, улсын дотор лам нарын улс байгуулах болол-

1. «Үнэн» 1936. 4. 22.

2. «Үнэн» сонин. 1931. 5. 6. №102.

цоо олгохгүй байх, Зөвлөлт Монголын худалдаа эдийн засгийн харилцааг бэхжүүлэх бүх боломжийг ашиглан хөгжүүлэх нь чухал гэжээ. Шаардлага хангахгүй байгаа орос мэргэжилтнийг цаг тухайд нь манай талд мэдэгдэж буцаалгаж байх, монгол дахь орос иргэдийг тавин хувь хүртэл буцааж цөөлөх нь зүйтэй гэж хэлээд эцэст нь П. Гэндэнтэй уулзах хүсэлтэй байгааг уламжлахыг хүсчээ. И. В. Сталин С. Довчингийн саналыг хүлээж авсан мэт байвч цаашид ерөнхий сайдын орлогчоос зайлуулах аргыг боловсруулж, түүний оронд тавих хүнээ ч бэлджээ гэж үзэж болох байна.

1934 оны арван нэгдүгээр сарын 15-нд И. В. Сталин ерөнхий П. Гэндэнтэй уулзахдаа ерөнхий сайдын орлогчид ажил давхарлаагүй хүн тавих нь зүйтэй гэж анхааруулаад тэр тушаалд Х. Чойбалсанг тавих тухай ярилцсан нь их л яаруу шийдэхийг эрмэлзсэн нь илэрхий байна. Х. Чойбалсан 1934 онд тодорхой биш ажлаар Моквад удаан хугацаагаар байсан юм. Тэр уулзалт дээр И. В. Сталин, П. Гэндэн нар Х. Чойбалсанг ерөнхий сайдын орлогч болгох гэж байгаагаа өөрт нь танилцуулжээ.

Х. Чойбалсан: —Би мал аж ахуйн яамны сайд хүн тэр ажилдаа л баймаар байна гэхэд,

И. В. Сталин: —Та энэ ажилд очлоо гээд малаасаа холдохгүй харин ч ойртоно гэсэн нь хэрэг дээрээ Х. Чойбалсанг дэвшүүлсэн томилолт болов. Ийнхүү ажил давхарласан гэдэг шалтгаар С. Довчинг ерөнхий сайдын орлогчоос өөрчилсөн нь 1934 оны нэгдүгээр сарын 11-ний уулзалт дээр тавьсан асуудалтай холбоотой нь ойлгомжтой юм. Ингээд С. Довчингийн оронд Х. Чойбалсанг 1935 оны эхээр ерөнхий сайдын орлогч болгожээ.

Дотоодыг Хамгаалах Газрыг яам болгон өөрчлөн байгуулж түүний сайд, орлогчийг томилох тухай хэлэлцсэн Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1936 оны хоёрдугаар сарын 26-ны өдрийн 49 дүгээр хурал дээр С. Довчин хэлэхдээ: «Дотоодын Хамгаалахыг Дотоод Яам болгосон явдалд түүний удирдлагыг шинэчлэхийг ярьж байна. Үүнийг шинэчлэх эсэх нь ДХГ-ын хуучин явж ирсэн ажлын байдал лугаа холбогдох бөгөөд гэтэл... Дотоодыг Хамгаалахын явуулж ирсэн ажилд дутагдал үлэмжхэнээр үл барам, ард түмнийг айлгадаг хэмээсэн нь үнэн байна. Иймийн тул хуу-

С. Довчин ажлын дутагдлыг арилгаж, сайжруулахад чиглэсэн дор дурдсан зүйлийг санал болгожээ. Үүнд:

1. Бидний дайсан гагцхүү гадаад бус дотоод ч буй. Шинэ эргэлтийн замыг хазайлгаж хэлбийлгэхийг оролдсон. Үүнийг зөвөөр биелүүлэх нь чухал. Энэ дутагдлыг засах талаар нам засгаас арга хэмжээ авсан. Энэ зүйлүүд манай улсын тусгаар тогтносон байдлыг улмаар бататгаж хөгжүүлэхэд чухал холбогдоно. Холбоот улсаас урд ч тусалж байсан, хойшид ч тусална. И. В. Сталинаас Америкийн сонин сурвалжлагчид хэлсэн үгийг Монголын ард түмэн баяртайгаар хүлээн авах хэрэгтэй. Гадаадын байдал ийм хүнд байхад нам ба засгийн удирдлага нь хатуу бат нэгдэлтэй байх нь чухал.

2. Дотоодыг Хамгаалахын дутагдал ба алдаа нь нөхөр Намсрайд холбогдоно. Энэ нь манай хувьсгалын эсэргүү нартай тэмцэх тэмцлийг сулруулж, гэмгүй хүмүүсийг хэрэгт татаж байсан төдийгүй, ард түмэн ч хамгаалахаас айх, хальтрах явдал үзэгдэж байсан болой. Энэ талаар манай нам засгийн удирдлагыг өөрчлөх хүртэл арга хэмжээ авсан. ДХГ-ын ажлыг урьд аль ч хуралд шүүмжлэн гаргаж яваагүйг буруугаар ойлгож үл болно.

3. Лам нар нь шашны зузаан хүч бүхий аппарат мөн. Энэ нь улс төр ба ардад ямар ч ашиг тусгүй нь тодорхой. Нөгөөтэйгүүр улс орныг батлан хамгаалах хүчийг бууруулах, монгол улсын дайсан болох этгээдийг даллаж байна. Илтгэлийн дотор ардаас лам нарын хэрэглэж байсан зүйлийн дүнг 27 сая хэмээн тэмдэглэсэн нь хамгийн доод хэмжээ бөгөөд үүнийг хянан үзвээс жил тутам 40 сая төгрөгөөс доошгүй мөнгө зарцуулагдаж байна.

4. Толгой лам нартай тэмцэх явдлыг сулруулж байсан нь энэхүү холбирч гуйвагч нөхдөд ноогдох болно. Тэдгээрийн толгойг илж, нугалаа болно хэмээн айх явдалгүй. Энэ тухай эхний үед зөв аргаа завдаж чадахгүй байсан нь сүүлийн үест авсан арга хэмжээ нь өөрийн улсын цаашид бататгах явдалд шууд холбогджээ. Гэтэл энэхүү зөв арга, тэрхүү гуйваж найгах этгээдийг барууны явуулга хэмээн үзэж байсан.

5. Ардын аж ахуйтныг хөгжүүлэх нь үйлдвэрлэх хүчинд чухал холбогдоно. Бараа товаар элбэг байлгах нь мөнгөний ханшийг дээшлүүлэхэд чухал болно. 25 (1935) онд тус

улсад ирүүлэх зарим нэгэн үндсэн барааг туйлын багаар төлөвлөн ирүүлсэн болой. Мөн орон нутгуудаар тэгшитгэн хуваарилах явдал дутагдалтай. 1935 оны барааны төлөвлөгөө багадсан шалтгаан нь дотоодын гаргах зүйл бага, гадаадаас ирүүлэх нь их байснаас болжээ. Бараа товаарын ажлыг өдөр тутмаар улирах явдлыг сайжруулах нь чухал.

6. Улсын орлого, зарлага нь өнгөрсөн жил (1935 он) 10 сая гаруй төгрөгөөр нэмэгдсэн нь улс орныг батлан хамгаалах хүчийг зузаатгах хүч болов. Энэ нь манай орны аж ахуйд ямар ч саадгүй болно. Энэхүү төсвийг гүйцэтгэхэд нийтийн хүчээр биелүүлэх хэрэгтэй. Үүнд арвилан хэмнэх шалгах, байцаах хэрэгтэй¹ гэжээ.

1936 оны 11 дүгээр сард С. Довчингийн Сангийн Яамны сайдаар 10 жил амжилттай ажилласныг ойг төр засаг, Намын төв байгууллагаас ёслол тэмдэглэжээ. Энэ нь удирдах ажилтны улс эх орондоо үр бүтээлтэй ажилласны ойг тэмдэглэдэг уламжлал манай улсад байгаагүй учир шинэ зүйл байв.

Нөгөө талаар С. Довчин нь тухайн үедээ хамгийн удаан ажилласан төрийн сайд төдийгүй Монгол улсын сан хөрөнгийг үүсгэн байгуулж бэхжүүлж арвижуулахад онцгой хувь нэмэр оруулсан учир түүний гавьяа зүтгэлийн үнэлэлт байв.

«Нөхөр Довчингийн Сангийн Яамны сайд болсны 10 жилийн ойд баяр хүргэе» гэсэн түүний том зурагтай өгүүлэл «Үнэн» сонины 1936 оны 11 дүгээр сарын 17-ны дугаарын 1, 2 дугаар нүүрт нийтлэгджээ. Тус сонинд Д. Догсомын гарын үсэг зурсан БНМАУ-ын Бага Хурлын Тэргүүлэгчдийн баярын бичиг, Х. Чойбалсангийн гарын үсэгтэй БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн баярын бичиг, Д. Лувсаншарав, Б. Баасанжав нарын гарын үсэг зурсан МАХН-ын Төв Хорооны баярын бичиг, «Үнэн» сонины газрын баярын бичгүүд нийтлэгджээ. Түүнд өгүүлснээс үзвэл С. Довчин монгол улсын сан хөрөнгийн төв байгууллагыг толгойлон, улс орны эдийн засгийн өндөрлөгийг улсын гарт төвлөрүүлж, эдийн засгийн талаар бие дааж, тусгаар тогтнохын төлөө тэмцлийн 10 жилийн ажлын үр дүнг дүгнэсэн үнэлэлт байв. Улсын Бага Хурлын баярын бичигт: «Манай Монголын жинхэнэ малчин ардын дотроос төрж гарсан эдү-

1. НТА. ф. 4. Д. 5. ХН. 181. х. 74—75.

гээ Улсын Бага Хурлын гишүүн, Сангийн Яамны сайд, улсын банкны дарга н. Довчин болбаас өөрийн мэдлэг, сурлагыг идэвхтэйгээр өндөрлөн улсын хүчинд зориулж чадсан учраас Сангийн Яамны сайдын үүргийг гүйцэтгэхдээ ер осолдож эндсэн газаргүй дан ганц өөрийн улсын төлөө үнэн санаа хүчээ шавхан гаргаж зүтгэсэн»¹ юм гэжээ. Цааш нь «Аливаа улс өөрийн улс гэрийг тогтоож, бататган хөгжүүлэх явдал болбаас гагцхүү эдийн засгийг бадруулан, санхүүгийн хөрөнгө зорийг арвитган хурааж, өсгөн үржүүлэх ба түүний гол журмыг сахих явдалд гүнээ холбогдоно. «Эл зарчмыг ямагт барьж, тус улсын сан хөрөнгийг арвижуулах талаар их зүтгэл чармайлт гаргаж үр дүнд хүрсэн хүн бол С. Довчин гэдгийг тодорхойлжээ. «Улсын санхүү ба мөнгөн хөрөнгийг бататган бэхжүүлж, зузаатгах, хийгээд ардын бүхий л төрлийн аж ахуй ба үндэсний соёл боловсролыг бэхжүүлэх, улс орныг батлан хамгаалах, манай улсын үндэсний тусгаар тогтносон байдлыг бэхжүүлэхэд ихээхэн амжилт гаргаж.. санхүүгийн ажлын дадлага мэргэжлийг олж чадсаны дээр санхүүгийн бүхий л ажилд хэрэглэгдэх шинэ хүчнүүдийг төрүүлэхэд туйлын их чармайлт гаргасны үрээр санхүүгийн үндсэн мэргэжилтэн улмаар олшрон төрж чадсан байна»² гэж МАХН-ын Төв Хорооны баярын бичигт өгүүлжээ. С.Довчингийн Сангийн Яамны сайдаар 10 жил ажилласны ойд зориулсан хэвлэлийн нийтлэлээс үзвэл шинэ монголын эдийн засаг, банк, санхүү зээлийн системийг үүсгэн хөгжүүлэхэд С. Довчингийн гавьяа зүтгэл асар их юм. С. Довчинд ирүүлсэн Ардын Сайд нарын Зөвлөлийн баярын бичигт: «нөхөр Довчин нь нам, засгаас даалгасан үүргийг үнэнч шударгаар биелүүлж ирсэн их гавьяа нь өөрийн улс гэрийг тогтоож, бататган.. шинэ хүчнийг оргилуулан төрүүлж, улсын санхүүгийг эрх ашгийг гартаа барьж түүнийг хөгжүүлэн чадахыг гол зорилго болгосон юм»³ гэжээ. Сангийн Яамны хамт олны хурлаас сайд нөхөр Довчин бол Монгол улсын санг арвижуулан хөгжүүлж, мэргэжлийн боловсон хүчнийг бэлдэхэд их гавьяа байгуулсан учир түүний нэрэмжит газар бий болгохыг хүссэнийг үндэс болгон БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн 1936 оны ар-

1 «Үнэн» сонин 1936. 11. 17.

Мөн тэнд.

3. Үнэн, 1936. 11. 17.

ван нэгдүгээр сарын 21-ний өдрийн 382 тоот тогтоолоор С. Довчингийн «Сангийн Яамны сайдын 10 жилийн ойн үүрдийн дурсгал болгон санхүүгийн техникумын сургуулийг нөхөр Довчингийн нэрийн дор байгуулах хэмээсэн нь зүйтэй тул ёсоор болгон баталж хойш явуулан гүйцэтгүүлсүгэй» хэмээн тогтоож санхүүгийн техникумыг С. Довчингийн нэрэмжит болгожээ. С. Довчингийн нэр хүнд их өссөн нь юуны өмнө Монгол эх орныхоо хөгжил цэцэглэлтийн төлөө авьяас билгээ зориулсан түүний цуцалтгүй хөдөлмөр, үрдүн, ажил хэргийн өргөн мэдлэгтэй, нөгөө талаар түүний ажилч хичээнгүй байдал, үнэнч шударга чанар, хүнлэг энэрэнгүй зан чанарыг шингээн эзэмшсэн тэргүүний ажилтан байсантай холбоотой юм. Дээр дурдсан бүхий л шинж С. Довчингийн үйл ажиллагаанд ажиглагддаг.

С. Довчингийн баримталж байсан улс орны эдийн засгийн хөгжлийн асуудалд мөнгө зээлийн бодлого тодорхой байр эзлэнэ. Мөнгийг хав дарах бус эргэлтэд түргэн оруулж «үржил чанартай» зарцуулан ашиглахад зээлийн бодлого их ач холбогдолтой гэж үзэж байв. Тийм учраас С. Довчин зээлийн бодлогод ихээхэн уян хатан хандаж, түүнийг байнга дэмжиж байв. Энд нэг жишээ дурдъя.

1938 онд ардын аж ахуйтанд олгох зээллэгийн тухай Сангийн Яамны сайд, Монгол банкны дарга С. Довчингийн илтгэлийг МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 1938 оны III сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцээд ардын хувийн аж ахуйтны мал сүргээ өсгөх, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэхэд зориулан урт хугацаатай 1 сая 550 мянган төгрөг, богино хугацаатай 1 сая 500 мянган төгрөг олгохоор тус тус төлөвлөснийг зүйтэй хэмээн үзжээ². Тухайн үеийн нам засгийн бодлого нийгэм эдийн засгийн аливаа асуудалд коммунист ангичлах бодлого баримтлан ялангуяа ардын аж ахуйтны ядуу доод хэсгийг дэмжих, чинээлэг хэсгийг хавчин хязгаарлах бодлого баримталж байв. Гэтэл С. Довчингийн төлөвлөснөөр үр ашигтай зүйл л хийвэл, «үржил чанартай» ашиглавал малаа өсгөж бүтээгдэхүүнээ нэмэгдүүлэхэд бүрэн чиглэвэл хөрөнгө чинээний байдлыг харгалзахгүйгээр нийт ардын аж ахуйтанд ол-

1. УТГА. ф. 1. Д. 2. ХН. 599. х. 72.

2. НТА. ф. 1. Д. 6. ХН. 141. х. 2—4.

гохоор төлөвлөн хэрэгжүүлжээ. Урт хугацааны зээлийг олгохдоо:

1. Уг зээлийн 33 хувийг үржлийн ба сайн үүлдрийн мал худалдан авахад, ердийн ба бүх төрлийн тээврийг хөгжүүлэх, түүний техник хэрэгслэлийг авахад зориулах

2. Ядуу, дунд аж ахуйтнаас хөнгөн маягийн үйлдвэр байгуулах, хөнгөн үйлдвэрийн сайн дурын нэгдэл байгуулахад 1 зуун мянган төгрөг, цэргийн ар гэрт 4 зуун мянган төгрөгийг тус тус олгох, мөн баян чинээлэг аж ахуйтнаас энэ ажлыг эрхлэн хийвэл нэгэн адил зээл олгоно хэмээсэн нь санхүүгийн үүрэг нь хувиарлах, хянах үүрэгтэй гэж үзэж байсан нь С. Довчингийн онолын гол баримтлал байв.

С. Довчин тухай үеийн хамгийн нэр хүндтэй удирдагчийн нэг байжээ. Тийм учраас түүний нэр хүндийг Дотоод Яам ч ашиглах оролдлого хийж байв. Тухайлбал 1937 оны IX сард гучаад оны хувьсгалын эсэргүү улс төрийн хэрэг гэгч их баривчлагын эхнийх болох анхны арван дөрвийн хэрэг гэгчийг таслан шийтгэх шүүх хуралд С. Довчинг улсын яллагчийн бүрэлдхүүнд оруулан томилжээ. Мэргэжлийн болон ажил төрлийн талаар хууль зүйн ямар ч холбогдолгүй хүнийг тэр бузар булай ажилдаа татан оруулсан нь зөвхөн түүний нэр хүндийг л ашиглахад оршжээ.

1937 оны 10 дугаар сарын 22—26-нд хуралдсан МАХН-ын Төв Хорооны III бүгд хурал Монгол дахь хувьсгалын эсэргүү Японы тагнуулын байгууллагыг илрүүлэн баривчлав гэж бүх нийтэд зарласан юм. Бүгд хуралд: Тус улсын хувьсгалын эсэргүү нараас хорлон сүйтгэсэн аргууд ба түүний хор үлдэгдлүүдийг устган арилгах тэмцэл хийгээд манай зорилгын тухай А. Амарын илтгэл, тус улсын дотор бугшин байсан Японы эзэрхэг түрэмгий нарын тагнуул төлөөлөгч нарыг илрүүлэн олсон улс төрийн туршлагаууд ба тэдний аюул заналын тухай Х. Чойбалсангийн илтгэл, намын ажлын дутагдлыг арилгаж, улс төрийн талаар санаа амирлангуй байхыг устгаж, ардын дайсан хоёр нүүртэн лүгээ тэмцэх аргуудын тухай Д. Лувсаншаравын илтгэл, 1938 оны улсын орлого, зарлагын төлөвлөгөө ба улсын сан хөрөнгийг хулгайлан шамшигдуулах явдалтай тэмцэх ба арвиалан хэмнэх явдлын тухай С. Довчин нар тус тус илтгэл тавьсан юм. А. Амар, Х. Чойбалсан, Д. Лувсаншарав нарын илтгэл нь Дотоод Яамнаас илрүүлэн баривчилсан хувьсгалын эсэргүү Японы тагнуулын байгууллага гэгч нь

үнэн бодит зүйл гэдгийг нотолж, нийтэд итгүүлэн үнэмшүүлэхэд чиглэжээ. С. Довчин илтгэлдээ: «Монгол улсын тусгаар тогтнол хийгээд Зөвлөлийн засагт Холбоот улсын хоорондын холбоо найрамдлыг таслан эвдэхийг оролдох дайснуудыг цэвэрлэсэн эрүүл бат ар талтай байваас зохих цаг үест... хоёр улсын холбоо найрамдлыг зузаатгах зорилгуудыг амжилттай гүйцэтгэж байна»¹ гэж илтгэлдээ Монгол Зөвлөлтийн сайн хөршийн харилцааг бэхжүүлэх тухай тэмдэглэжээ. Цааш нь улсын төсөв хөрөнгийн зарцуулалт, санхүүгийн хяналт шалгалтын асуудалд хандаж төсөв хөрөнгийг үрж сүйтгэн, мөнгөн санхүүгийн хууль дүрэм зөрчиж байгаа элдэв дутагдлын тухай дэлгэрэнгүй өгүүлжээ. «Манай санхүүгийн хууль нь улсын бүх албан яам байгууллагуудаас цөмөөр дагаж биелүүлбээс зохих зүйл билээ. Гэтэл сүүлийн үест цэргийн яамны талаар санхүүгийн хяналт шалгалтыг явуулж чадахгүй» байна. «Улсын нэгэн яам нь төв засгаас тусгаарлаж засгийн хууль дүрмийг хэрэгсэхгүй. Харин улсын дотор тусгаар нэгэн улс буй болох»² нь уу гэмээр хачирхалтай байна гэж цэргийн яамны санхүүгийн үйл ажиллагаанд гарч буй дутагдлыг баримт нотолгоотой тавьжээ. Цэргийн Яаманд «улсын сангаас жил бүр их хэмжээний хөрөнгө мөнгийг тавин олгосныг ямар ч нарийн тодорхой төсөв төлөвлөгөөгүй зарцуулж байсны харгайгаар ямар ямар зүйлүүдэд хэд хичнээн хөрөнгө зориулан хэрэглэж агсныг байцаан мэдэх баримт тэмдэггүйд хүрсэн»³ байна. «Нэгэн жишээ дурдваас энэ 1937 оны дотор цэргийн яам хорь шахам удаа будааллага цайллага хийж, түүнд угаас тусгай төлөвлөсөн мөнгө үгүй атал цэргийн хоол, хүнсний зүйлд зарцуулах мөнгөнөөс хэдэн арван мянган төгрөгийг зарцуулсан байх ба сайшаал шагнал туйлын хэтэрхийгээр явуулснаас үлэмжхэн хөрөнгийг» зарцуулжээ. «Бас бусдаас авах авлага, бусдад өгөх өглөг тус тусдаа нэжгээд төгрөг хүрч байна»⁴. Бас төсвийг хэтрүүлэн зарах явдал их байгааг зарим байгууллагуудаар жишээ болгон авчээ. Хоршоодын Төв Холбоо 1936 оны төсөвт захиргааны зардлыг 1 сая 600000 төгрөгөөр, Улсын Худалдааны газар

1. НТА. ф. 4. Д. 6. ХН. 1. х. 176.
2. НТА. ф. 4. Д. 6. ХН. 1. х. 177.
3. НТА. ф. 4. Д. 6. ХН. 1. х. 178.
4. Мөн тэнд.

7 сая 700000 төгрөгөөр тус тус хэтрүүлэн заржээ. Түүнчлэн бусдаас авах авлага Монгол Тээх 1 сая 340000 төгрөг, Гар үйлдвэрийн ерөнхий хороо 324000 төгрөгт хүрчээ.¹ «Засгийн газраас улсын сан хөрөнгийг арвилан хэмнэхийг шаардсаар атал яам, аж ахуйн газрууд түүнийг хайхарч хэрэгсэхгүй нам, засгийн тогтоод шаардлагаас гадуур явж ард олны хөрөнгийг үрэгдүүлэн шамшигдуулах, сүйтгэх явдал болбоос»² туйлын хариуцлагагүй хуучин бүдүүлэг явдлын үлдэгдэл мөн болой.

1938 оны улсын орлого, зарлагын тухайд гаалийн болон худалдааны, ардын аж ахуйтнаас хураах татварыг нэмэхгүй боловч импортын бараа нэлээд нэмэгдэж бараа гүйлгээ өснө. Харин дээд лам нараас хураах татварыг нэмэхээр төлөвлөж байгааг мэдэгджээ.

Гэндэн, Дэмидийн толгойлсон хувьсгалын эсэргүү Японы тагнуулын хэрэг гэгч ор үндэсгүй зохиомол хэргээ үнэн бодит зүйл хэмээн итгүүлэхэд бүгд хурлын үйл ажиллагаа чиглэжээ. Гэтэл С. Довчин илтгэлдээ өөрийн сэдвээс хальж хувьсгалын эсэргүүчүүдийг бусдын адил буруутгаж муучилсан зүйл хэлээгүй нь асуудалд хамгийн бодитой хандан туйлшардаггүй байсны тод жишээ болно.

Нам, төрийн удирдлагад ажиллан их баривчлагаас үлдээд байсан А. Амар, С. Довчин, Д. Догсом, Д. Дорж, Д. Лувсаншарав, Б. Баасанжав нарын цөөн хүнийг 1939 оны 2 дугаар сараас 7 дугаар сарын хооронд баривчилсан юм. Ерөнхий сайд Амар, Дотоодын Яамны орлогч сайд Б. Лосолтой 1938 оны нэгдүгээр сарын 19-ний өдөр ярилцахдаа А. Амараас: «Довчин, Дорж нарыг баривчлах магадгүй байна. Чи аргалж эв зүйг нь олж бариулахгүй бийг бодоорой, илээр шууд татгалзаад болохгүй шүү. Дотоод Яамны ажлыг цааш аажмаар сулруулах хэрэгтэй, Суларсны дараа Намын Төв Хорооны IV бүгд хурлаар Дотоод Яамны ажлыг шүүмжлэн хэлэлцүүлж, барих хорих явдлыг зогсоох болно. Одоо манай зарим хүнийг барьж магадгүй. Барихаар шийдсэн хүмүүсийг надад мэдэгдэж бай»³ гэжээ. А. Амар болон бусад удирдагчид албан хаагчид цөм хувьсгалын эсэргүү гэгч зохиомол хэргийн эсрэг ямагт байсан

1. НТА, ф. 4. Д. 6. ХН. 1. х. 180.

2. Мөн тэнд.

3. УАБХЕГ-н архив, Б. Лосолын хэрэгт.

боловч ил шууд хэлж, шүүмжилж засах ямар ч боломж байгаагүй юм. Хэрэв түүнд эмзэглэсэн зүйл сэрвийз сэртийвэл амь насы нь бүрэлгэх аюултай байсан болохоор дотроо шаналж айж явсан цаг байв. Улс үндэсний төлөө шаналж явсан хүний нэг нь С. Довчин билээ. Түүнийг барихгүй удаасны учир нь албан ажлын болон бусад асуудлаар ямар нэг өө сэв шалтаг гарахгүй байсных болбуу. Нөгөө талаар С. Довчинг эх орноосоо урваж, эсэргүү болсон гэхэд олон түмэн хэр зэрэг итгэн үнэмших вэ гэдэгтэй ч холбоотой байсан байж болох юм.

УЛС ТӨРИЙН ХЭРЭГТ БАРИВЧИЛСАН НЬ

Х. Чойбалсан 1938 оны IX сараас 1939 оны II сарын эх хүртэл учир битүүлэг ажлаар ЗХУ-д байгаад эргэж ирмэгцээ л С. Довчинг яаралтай барих болсныг шадар туслагч Д. Лувсаншаравтаа мэдэгджээ. Д. Лувсаншараваас 1939 оны II сарын 11-нд Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн нууц хурлыг Довчингийн оролцоогүй яаралтай хийлгэжээ. Тус хуралд Д. Лувсаншараваас «Мөрдөн байцаалтад байгаа орлогч жанжин агсан Дамба, штабын Намсрай, Улс төрийн газрын Найдан нарын мэдүүлгээр илэрсэн хэргийн тухай Чойбалсангаас миний биед мэдэгдсэн нь тус Төв Хорооны Тэргүүлэгч гишүүн Довчин Дорж нар.. юм гэжээ. Тус хурлаас Довчин, Дорж нарыг Төв Хорооны Тэргүүлэгч гишүүний үүрэг ба намын гишүүнээс хөөн зайлуулж уг хэрэгт нь баривчлахыг Чойбалсанд даалгасугай»¹ гэснээр Х. Чойбалсангаас хурлын дараа мөн өдрийн 12 цагт С. Довчинг өрөөндөө утсаар дууджээ. С. Довчин олон хүн хүлээсэн ажил ихтэй байсан учир 13 цагийн үед Чойбалсангийн өрөөнд дуудагдаж очоод эргэж ирэлгүй сураггүй болжээ.

С. Довчинг улс төрийн хэрэгт баривчлахын өмнөхөн барих зөвшөөрлийг ЗХУ-ын Дотоод хэргийн ардын комиссараас (НКВД) ЗХУ-ын удирдлагад хүссэн байна. Үүнд: «ЗХУКН-ын Төв Хороо нөхөр Сталинд, СССР-ийн Ардын Комиссаруудын зөвлөлийн дарга нөхөр Молотовт, СССР Батлан Хамгаалах Ардын Комиссар нөхөр Ворошиловт:

Монголын Сангийн Яамны сайд Довчин, Худалдаа тээврийн Яамны сайд Дорж нарыг баривчлах зөвшөөрөл хүсч

1. УАБХЕГ-ын архив. ХН, 1175, II хавтас, 69 дэх тал.

байна. Тэр хоёр хувьсгалын эсэргүү нэгдсэн төвийн удирдлагын гишүүн болох нь 1938 оны 2 дугаар сард илэрсэн бөгөөд энэ төвд Троцкистуудын үлдэгдэл Гэндэн, Дэмидийн байгууллага, буриадын үндсэрхэг үзэлтэн болон пан Монголын Япон талыг баримтлагчид нэгддэг юм. Довчин бол пан Монголын Японы жигүүрийн төлөөлөгч, Дорж бол Троцкистоор энэ төвд байдаг.. Довчин санхүүгийн салбарт, Дорж бүтээгдэхүүний эрэлт гүйлгээнд хорлон сүйтгэх ажиллагаа явуулж байгаа нь батлагдаад байна. Тэд хоёулаа Амартай ойр дотно түүнийг дэмжицгээдэг. Энэ хоёрыг баривчлах зайлшгүй шаардлагатай гэж үзнэ.

СССР-ийн НКВД-ийн орлогч корпус командлан захирагч Фриновский»¹ гэжээ. Мөн Бериягаас С. Довчин, А. Амар нарыг барих зөвшөөрлийг Сталинаас авч баривчлах цаг хугацаа тодорхой зааж Х. Чойбалсанд даалгажээ. Х. Чойбалсан ч И. В. Сталины нууц даалгаврыг дуулгавартай биелүүлж С. Довчинг яаралтай баривчилсан нь их залуурчийнхаа заасанд хэрхэн ханддаг байсны жишээ мөн.

С. Довчинг дайчлан баривчлах ордер, хорьж байцаах тогтоол байхгүй зэрэг улс төрийн хэрэгтний хэргийн бүрдэл дутуу байгаа нь хачирхалтай юм. С. Довчинг худал хэрэг хүлээлгэх гэж мөрдөн залхааж байгаад 1939 оны VII сарын үед ЗХУ-ын Чита хотод нууцаар аваачиж тэнд улс төрийн хэрэгтэн монголчуудыг мөрдөн байцаахаар ирж ажиллаж байсан НКВД-гийн Наседкинээр толгойлуулсан мөрдөн байцаах группийнхний гарт өгчээ. Тэнд хүргэгдэн очсон монголчуудыг туйлын харгис хэрцгий аргаар мөрдөн байцаан залхаадаг байжээ. Гэвч Монголчууд мөрдөн бйцаалтын эхний үед хилс гүжирдэн тулгасан хувьсгалын эсэргүү Японы тагнуулын хэрэг гэгчийг нэг ч хүн хүлээдэггүй байсныг Наседкиний группэд орчуулагчаар ажиллаж байсан Б. Ч. Балданогийн мэдүүлэг гэрчилж байна. Тэрбээр: «Чита хотод монголчууд эхний 1—2 удаагийн мөрдөн байцаалтад тулгасан хилс хэргийг хүлээхгүй болохоор өдөр шөнөгүй жижүүрлэн байцаах, хоол ундгүй зовоон тарчлаах, тэсвэрлэшгүй хэрцгийлэн зодсоноор тэд тулгасан хэрэг хүлээсэн юм» гэжээ. Тулгасан хэргээ хүлээлгэсний дараа 30—45 орчим хоног болоод Москвад аваачиж Лефортовскийн шоронд

1. Я. Батсуурийн бичсэн. Тэр жилүүдийн тухай НКВД-гийн архиваас бичиж байна. «Маш нууц» сонин. 1993 он, дугаар 2.

хорьжээ. Тэнд очсоны дараа мөрдөн байцаалтын залхаал-
тыг үл тэсвэрлэх хилс хэрэг хүлээлгэсэн тухай НКВД-гийн
удирдлагад өргөдөл гомдол гаргаж байсан боловч түүний
анхааран үзэж шийдвэрлэсэн баримт үгүй байна.

С. Довчингийн мэдүүлэг гэж 1939 оны IV сарын 11-нээр
өдөрлөсөн хуучин монгол бичгээр машиндсан 25 хуудас ба-
римт байх бөгөөд түүнд мөрдөн байцаагч, байцаагдагчийн
гарын үсэг аль аль нь байхгүй нь их хачирхалтай байна.
Түүний орос орчуулгын машиндсан 39 хуудас байна. Тийм
том мэдүүлгийг нэг өдөр нэг хүнээс авах боломжгүй гэж мэр-
гэжлийн хүмүүс үздэг. Түүнд: «14-р онд (1924) Намын III
их хурлын өмнөхөн Сангийн Яамны сайд Данзан дуудаж
байна хэмээсэн ёсоор гэрт нь очвол «Данзангаас одоо ма-
най улс бол энэ байдлаас цааш тусгаар улс болж чадахгүй
бөгөөд СССР улс нь манай Дотоод хэрэгт оролцож байна.
Бид нар СССР улсаас харилцаа холбоог тасалж өөр хүчир-
хэг хөрөнгөтөн улсыг түшиглэсэн тусгай улсыг байгуула-
хаар миний бие тэргүүтэй ажиллаж байна. Та нар үүнийг
ойлгож хань нөхдийг олж байх хэрэгтэй хэмээсэн. Иймд ми-
ний бие Данзанг баригдсанаас хойш их л айж явсан»¹.

1924 онд гадаад яамны эрхэлсэн түшмэлээр ажиллаж
байхад ерөнхий сайд, Гадаад яамны сайд өвгөн Цэрэндор-
жоос «манай улс нь СССР улсыг түшиглэж хөгжих явдалд
тусгүй. Иймд олон Монгол овогтон бүгдийг нэгтгэн Нармай-
их улсыг байгуулж, хүчирхэг их хөрөнгөтөн улсыг түшиг-
лэж явбаас сая манай монголчууд ихээхэн нэртэй том улс
болж тусгаар тогтнож чадах болно»² гэв. 1926 онд Сан-
гийн Яамны сайд болсноос хойш миний бие нам засгийн
удирдлагад оролцож эхлэхийн хамт ерөнхий сайд агсан
феодал Цэрэндорж, түүний орлогч сайд агсан А. Амар, На-
мын Төв Хорооны дарга Дамбадорж, Цэргийн зөвлөлийн
тэргүүлэгч Жадамба, Улсын Бага Хурлын дарга хазгар
Гэндэн нар ба нэн ялангуяа буриадын үндэсний үзэлтэй
хуучин оюутан Цэвээнжамсранов, Цэдэн-Иш, Цогтбадам-
жав нараас МАХН-аас тус улсыг хөрөнгөтний замаас га-
дуур хөгжүүлж, аажмаар нийгэм журмын замд дэвшүүлэх
хэмээсэн улс төрийн бодлогуудыг эсэргүүцэж тус улсыг зөв-

1. НАБХЕГ-ын архив. ф. ц. 1175. х. 3.

2. Мөн тэнд

лөлийн засагт Холбоот улсаас харилцаа найрамдлыг салгаж гадаадын эзэрхэг улсуудыг түшиглэж бүх монгол үндэстнийг нэгтгэсэн нармай их улсыг байгуулж, хөрөнгөтний замаар хөгжүүлэх хэмээсэн нууц бодлогуудыг биелүүлэх арга маяг болгон хэрэглэж, байв гэжээ.

Тэд СССР-ээс салж аль нэг хүчирхэг хөрөнгөтөн улсыг түшиглэж феодалын хаант улсыг байгуулах зорилт тавьж байсан гэх зэргээр баруунтан гэгчид холбогдуулж байсан бүх ял зэмлэлийг С. Довчинтой холбож баруунтан болгоод түүнээ хувьсгалын эсэргүү гэжээ.

С. Довчин 1937 оны IX сар хүртэл Гэндэн, Дэмидийн эсэргүү байгууллагад тэдний удирдлагаар ажиллаж, мөн оны IX сараас гол удирдлага цохигдсон тул Сангийн Яам, Улсын банкин дээрх хувьсгалын эсэргүү ажлыг өөрөө удирдаж цаашид шинэ эсэргүү байгууллага байгуулахад яаран бэлтгэж байсан. Ийм байгууллагыг хурдан байгуулахыг Амарас шургуу шаардаж байв. гэж мэдүүлэв гэжээ. Улс төрийн хэрэгтний хэргээ хүлээсэн хэмээх мэдүүлгийг зохиохдоо бодит байдалтай ойртуулах гэж чармайдаг байсан нь ажиглагдаж байна. С. Довчингийн эсэргүүгийн хамсаатан гэж өмнө өгүүлсэн есөн хүн бол урьд нь баруунтан гэж буруушаагдсан монголоо гэсэн сэтгэлтэй халуун эх орончид билээ. Тэдний үзэл баримтлал, үйл ажиллагаа нь С. Довчинтой нийлж байсан нь эргэлзээгүй. Б. Цэрэндорж (нас барсан), Ц. Дамбадорж (нас барсан) нараас бусад долоо нь хувьсгалын эсэргүү улс төрийн хэрэг гэгчид баригдаж цаазлагдсан юм. С. Довчинг баригдсанаас хойш «С. Довчингийн хувьсгалын эсэргүү бүлэг» гэж Чойбалсангийн хэлсэн үгэнд ч гарах болов. Ямар нэг нөлөө бүхий албан тушаалын хүнийг барьсны дараа түүний толгойлж байсан эсэргүү бүлэг, байгууллага гэсэн зохиомол зүйлийг сурталчлах болсонтой холбоотой байв.

С. Довчин эх Дуламжав, эхнэр Долгор нарын хамт өрхийн дотор гурван ам бүл байжээ. С. Довчинг баригдсаны дараахан 1939 оны III сарын 17-нд түүний эхнэр Галсандоржийн Долгорыг Сангийн Яамны Намын үүрийн бүх гишүүдийн хурлаар эсэргүүний гэр бүл хэмээн намаас хөөжээ.

Г. Долгор нь хуучин Түшээт хан аймгийн Дайчин бэй-

1. УАБХЕГ-ын архив, ц. 1175, х. 3.

сийн хошуу одоогийн Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын харъяат нягтлан бодохын мэргэжилтэй, 1930-аад оноос Санхарины Яамны даатгалын газар нягтлан бодохоор удаан ажиллажээ. С. Довчинг баривчлагдсанаас хойш насан өөд болох хүртлээ ганц бие, эсэргүүний гэр бүл гэж гадуурхагдан хавчигдаж, тарчиг ядуу амьдралтай их л ядарч зовж байж хошуухан нас баржээ. С. Довчинг 1965 онд цагаатгасан боловч гэр бүлд нь мэдэгдээгүй учир эхнэр, дүү нар нь сонч мэдэлгүй 1990 он хүрчээ. Ер нь С. Довчингийн ах дүү, түүний ач, зээ нар 1993 он хүртэл тодорхой мэдээлэлгүй байжээ.

1939 оны II сараас 1941 оны VII сар хүртэл 2 жил 5 сарын хугацаанд С. Довчинг яаж залхаан цээрлүүлсэн, ЗХУ-д хэзээ, хэдийд аваачсан зэргийг тодруулах баримт мэдээ манай улсад байхгүй билээ. ЗХУ-ын Дээд Шүүхийн Цэргийн Коллеги 1941 оны 7 дугаар сарын 5-нд буудан алах ял шийтгэн, мөн сарын 27-нд гүйцэтгэн цаазалжээ.

С. Довчинд холбогдуулсан улс төрийн хэрэг гэгчийг хянан нягтлаад худал ташаа зохиомол байсныг тогтоосон ЗХУ-ын Ерөнхий прокурорын 1965 оны 2 дугаар сарын 22-ны хариу, БНМАУ-ын Ардын Их Хурлын тэргүүлэгчдийн 1962 оны 57 дугаар зарлигийг үндэслэн БНМАУ-ын Дээд Шүүхийн бүгд хурлын 1965 оны 5 дугаар сарын 31-ний 042 дугаар тогтоолоор цагаатгаж, түүний иргэний нэр төрийг сэргээсэн юм. Мөн гуч дөчөөд онд улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгсдийг цагаатгах ажил эрхлэх МАХН-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны Комиссын 1990 оны нэгдүгээр сарын 10-ны өдрийн хурлаар С. Довчингийн МАХН-ын 1921 гишүүний нь сэргээн тогтоожээ.

С. Довчинг улс төрийн хэрэгт хилс баривчилж егүүтгэснээс хойш мартагдан замхарсан түүний нэрэмжит газрыг 1993 оны 10 дугаар сарын 6-ны өдрийн Монгол Улсын Засгийн Газрын хурлаас сэргээж, одоогийн эдийн засгийн коллежийг С. Довчингийн нэрэмжит болгохоор тогтоон шийдвэрлэв.

ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, БАЙР СУУРЬ

С. Довчин бол олноо өргөгдсөн Монгол улс байгуулагдсан 1912 оноос төрийн түшмэлийн албыг хашиж эхлэн Монгол оронд ардын хувьсгалт ялсан 1921 оны VII сараас 1939 оны II сар хүртэл шинэ төрийн албанд ажиллахдаа Мон-

гол улсын байлдан олсон эрх чөлөө тусгаар тогтнол, хил хязгаарын бүрэн бүтэн байдлыг хамгаалж, харийн дайсныг хөөн зайлуулах тэмцэлд биечлэн оролцож хувьсгалын ололтоо хамгаалах тэмцэлд авъяас билгээ зориулсан төрийн нэрт зүтгэлтэн байв. Тэрбээр Монгол улсын шинэ эдийн засгийн бие даасан байдлыг хангах эдийн засгийн төв байгууллага банк, Сангийн Яамыг 1924 оноос эхлэн 1939 онд улс төрийн хэрэгт баригдах хүртэл толгойлж, эдийн засгийн шинэ тогтолцоог бүрдүүлэх тэмцэлд гарамгай роль гүйцэтгэсэн нэрт эдийн засагч байв.

1924 онд Гадаад Явдлын Яамны эрхэлсэн түшмэл С. Довчинг Монгол улсын Гадаад Явдлын Яамны сайдын тушаалд А. Амартай өрсөлдүүлэн нууц санал хураасанд А. Амар нэг санал илүү авч ГЯЯ-ны сайд болжээ. Энэ хоёр хүн тухайн үедээ мэдлэг чадвартайд тооцогдож байжээ. Бас 1928 оны II сард БНМАУ-ын Ардын Сайд нарын Зөвлөлийн Ерөнхий сайдад А. Амар, С. Довчин хоёрыг өрсөлдүүлэн нууц санал хураахад мөн л А. Амар нэг илүү саналаар ялсан баримт байдаг. Энэ нь шинэ Монгол улсын гадаад харилцаа олон улсын байр суурийг бэхжүүлж, нэр хүндий нь өргөж чадах, монгол улсыг шинэчлэн хөгжүүлж, эдийн засгийн тусгаар тогтнолыг хангах итгэл, боловсрол, мэдлэг, соёл, зан харилцааны төв төвшин байдал С. Довчинд байсных буй заа.

1921 оны хувьсгал ялсны дараа Монгол улс, Монголын ард түмний өмнө чухлаар тавигдсан нэг том зорилт бол улс орны шинэ эдийн засгийг байгуулж бэхжүүлэн эдийн засгийн талаар бие дааж хөл дээрээ зогсох асуудал байсан ажээ. Энэ асуудлыг улсын өмнө хариуцаж байсан төр засгийн байгууллага бол Монгол улсын Сангийн Яам, Улсын банк байв. Энэ хоёр байгууллагын удирдлагад С. Довчин 1924—1939 онд ажиллаж дээрх зорилтыг биелүүлэхийн төлөө билэг авъяасаа зориулан тэмцэж байв. Аливаа улс орон, байгууллага, өрх гэрийн үйл ажиллагааг удирдах тэргүүлэх хүний алсын хараа, зохион байгуулах ур чадвар төрийн мэргэн ухаанаас ихээхэн хамаардаг.

С. Довчингийн толгойлж байх үеийн Монгол улсын сан хөрөнгө үсрэнгүй хөгжлөөр арвижин бэхжиж байжээ. Тэрбээр үзэл бодол байр суурийн талаар А. Амар, П. Гэндэн, Н. Жадамба нартай санаа нэгдэн ажиллаж байсныг түүхийн баримт нотолдог.

С. Довчин улсын сан хөрөнгийг арвижуулахдаа арвилан хэмнэх бодлогыг ард түмний аж амьдралыг сайжруулах зорилттой ямагт хослуулж байсанд оршино. Улсын чухал эх сурвалжийн нэг болж байсан албан татварын орлого нь хүн амын амьдралын түвшинг дээшлүүлэхэд чиглэж байв.

Албан татварын талаар бол хөнгөлөлтийг эрхэм болгож, татварыг оногдуулахдаа дээд хэмжээг нэмэхгүй байх, аппарататыг цомтгож төсвийг хорогдуулах, төсвийг хорогдуулахаар албан татварын нийт хэмжээг багасгах зарчмыг гол болгож байв. Ингэснээр ард олны амьдралыг сайжруулах чиг бодлогыг хэрэгжүүлж байв. Улсын төсвийн алдагдлыг албан татварыг нэмэх замаар нөхөх гэсэн хандлагыг С. Довчин улсынхаа цар хэмжээ багтаамжийг үл харгалзаж авах нэмэхийг урьтал болгов хэмээн шүүмжилж «таван настай хүүхдэд хорин таван настай хүний хувцас өмсгөх гээд байгаатай адил юм» гэж шүүмжлээд албан татварыг бодлогогүй, хамаагүй нэмж огт болохгүй, төсвийг багасгавал, татварыг нэг адил багасгана гэж үзэж байв.

Гаалийн талаар бол Монгол улсад орж буй бүх бараанаас улс орон харгалзахгүй, хоршоо, худалдаа, хувь хүн хэн боловч адил тэгш гаалийн татвар төлөх ёстой гэдэг зарчмыг баримталж байв.

Зээлийн бодлогын хувьд бол бүтээн босгох, үржил чанартайгаар (үр ашгийг нэмэгдүүлэх) ашиглах талыг гол болгон хүссэн бүхэнд аж ахуй бүрд хувь хүнд хэнд ч болов ашигтай л зарцуулбал жасын аж ахуйд ч зээл өгч болно гэдэг зарчмыг барьж байв.

С. Довчингийн төр засгийн алба хашиж байсан үе бол нэгд, 1921 оны хувьсгалын зорилтыг гүнзгийрүүлэн, улс орны нийгэм, эдийн засгийг шинэчлэх, ардчилсан өөрчлөлтийг хэрэгжүүлэн хөгжүүлэхийн төлөө тэмцлийн үе байв. Хоёрт, гаднын нөлөө шахалтаар хууль ёсыг гажуудуулж гэм зэмгүй олон хүнийг улс төрийн хилс хэрэгт баривчилж хэлмэгдүүлэх явдал газар авчээ. Гуравт, Монгол орны гадаад байдал ээдрээ төвөгтэй, Японы зүгээс манай орны тусгаар тогтнолд аюул занал учруулж байв. Нөхцөл байдал ийм байсан үед С. Довчингийн үзэл баримтлал улс, төрийн байр суурь нь улс орны эдийн засгийг бэхжүүлэн, сан хөрөнгийг арвижуулан орлогыг нэмэгдүүлж, зарлагыг багасгах санхүүгийн механизмыг боловсронгуй болгон хөгжүүлж ЗХУ-тай тогтоосон сайн хөршийн харилцааг зузаатгах Зөвлөлтийн сан-

хүү, зээлийн бодлогын туршлагыг санхүүгийн ажилд нэвтрүүлэхэд чиглэж байсан нь түүний үйл ажил, хэлсэн үг, бичсэн зүйлээс тодорхой байна.

С. Довчин бол хувьсгал ялсан анхны өдрөөс төр засаг, ард түмний үйл хэргийн төлөө чин үнэнчээр зүтгэж, тус улсын гадаад харилцаа, эдийн засгийг ардчилсан үндсэн дээр хөгжүүлэх, санхүү эдийн засгийн шинэ тогтолцоог шинжлэх ухааны үндэстэй бүрдүүлж төлөвшүүлэх, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, ардын төрийн албан татварын бодлогыг боловсруулах, үндэсний банк, санхүү зээлийн системийг байгуулж, мөнгөний шинэчлэлт хийх тэмцэлд тодорхой хувь нэмэр оруулсан юм. Тус улсын гадаад, дотоод худалдааг улсын гарт төвлөрүүлэх зэрэг нам, засгаас авч хэрэгжүүлсэн нийгэм-эдийн засгийн томоохон арга хэмжээнүүд С. Довчингийн шууд оролцоотой хийгдсэн бөгөөд улс орны эдийн засгийг хөгжүүлэхийн төлөө мэдлэг оюунаа зориулсан Монголын төрийн нэрт зүтгэлтэн байв. С. Довчингийн үйл ажиллагааг үнэн зөв үнэлж дурсгалыг мөнхжүүлэх, түүх намтрыг боловсруулж хэвлэн нийтлүүлэхийг санал болгож байна.

С. Довчингийн тухай судалгаа, түүхэн үнэлгээний асуудлыг улс төрийн талаар хэлмэгдэгсдийн судалгааны төвийн судлаачдын хурлаар хэлэлцэж дүгнэлт гаргав.

С. ДОВЧИНГИЙН БИЧИЖ НИЙТЛҮҮЛСЭН БҮТЭЭЛ

1. МАХН-ын IX их хуралд тавьсан шүүмжлэл. Үнэн. 1934. №87.
2. 1930 оны орлого, 1931 оны төсвийн тухай. С. Довчингийн илтгэлд гаргасан Намын Төв Хорооны тогтоол. Үнэн. 1930. №91.
3. 1932 оны орлого зарлагын хяналтын тооны тухай. Үнэн. 1932. №76
4. Албан татварын компаныг өргөнөөр явуулъя. Үнэн. 1931. №122, 126.
5. Албан татварын компаны тухай. Үнэн. 1931. №195.
6. Хөдөө аж ахуйн нэгтгэсэн албан татварын тухай Намын Төв Хороо, Намын Хянан Байцаах Төв Комиссын хавсарсан хуралд С. Довчингийн тавьсан илтгэлд гаргасан тогтоол. Үнэн. 1931. №102—103.

7. Хөдөө аж ахуйг нэгтгэсэн, албан татварын тухай С. Довчингийн илтгэлд гаргасан Намын Төв Хорооны тогтоол. Үнэн. 1932. №110.

8. 1933 оны улсын орлого, зарлагын тухай. С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоол. Үнэн. 1933 №29.

9. Цэргийн албан татварын тухай. Үнэн. С. Довчингийн илтгэлд гаргасан Намын Төв Хорооны тогтоол. Үнэн. 1933. №44.

10. 1924 оны улсын шууд хураах албан татварын гүйцэтгэл ба 1925 онд явуулах татварын бодлогын тухай С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоол. Үнэн. 1924. №96.

11. 1935 оны улсын орлого, зарлагын хяналтын тооны тухай С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоол. Үнэн. 1935. №10.

12. Жас ба цэргийн татварын тухай С. Довчингийн илтгэлд гаргасан Намын Төв Хорооны тогтоол. Үнэн. 1935. №18.

13. 1935 оны ардын мал аж ахуйгаас хураах албан татварын хуулийн тухай. С. Довчингийн илтгэлд гаргасан Намын Төв Хорооны тогтоол. Үнэн. 1935. №43.

14. 1938 оны III сараас ардын аж ахуйтанд урт, богино хугацааны 3 сая төгрөгийн зээл олгох тухай С. Довчингийн илтгэлд гаргасан тогтоол. Үнэн. 1938. №36.

15. Улсын орлого, зарлага, албан татварын бодлого ба санхүүгийн байдлын тухай. С. Довчингийн илтгэл. Түүнд гаргасан тогтоол. Үнэн. 1934. №26.

16. 1935 оны албан татварын хөнгөлөлтийн тухай. Ардын үндэсний эрх. 1935. №79, 80. Улсын 12 жилийн ой ба санхүүгийн хөгжил. Үнэн. 1933. №14.

17. Мал аж ахуй ба худаг усыг элбэгжүүлэх тухай. Ардын үндэсний эрх. 1938. №63.

18. Ардын мал аж ахуйд зээллэг олгох журмыг хэрхэн биелүүлэх тухай. Үнэн. 1938. №42.

19. Ардын хөрөнгө мөнгийг арвилан хэмнэе. Үнэн. 1936. №48.

20. Ардын үндэсний хувьсгалын 17 жилийн ой ба улсын санхүүгийн хөгжилт. Үнэн. 1938. №75.

21. Дээд анги ба ихээхэн орлого бүхий лам нараас хураах тусгай албан татварыг анхаарагтун. Үнэн. 1936. №63.

22. Дээд ангийн ба ихээхэн орлого бүхий лам нараас хураах албан татварын хуулийн тухай. 1937. Ардын үндэсний эрх. 1937. №60.

23. Монгол банкны 10 жилийн ой. Ардын үндэсний эрх. 1934. №60.
24. Монголын үндэсний хувьсгалын 14 жилийн ой ба тус улсын санхүү, албан татварын бодлого. Үнэн. 1935. №88.
25. Октябрийн хувьсгалын 17 жилийн ой ба улсын санхүүгийн үүрэг зорилго. Үнэн. 1934. №92.
26. Октябрийн хувьсгалын 20 жилийн ой ба Монгол улсын санхүүгийн үүрэг. Үнэн. 1937. №124.
27. Улсын орлого, зарлагыг гүйцэтгэхэд олон нийтийн хүчийг хандуулъя. Үнэн. 1931. №11—12.
28. Улсын дотоодын зээллэгийг идэвхтэй гүйцэтгэхийг уриална. Ардын үндэсний эрх. 1932. №9.
29. Тус улсын төгрөгийг алтан дэвсгэртэй хэрхэн болгосон тухай. Үнэн. 1928. №19, 23.
30. Одоогийн улсын санхүүгийн байдал ба зорилгын тухай. Ардын үндэсний эрх. 1934. №60.
31. Улсын ба албан татварын хуулиудын тухай гүйцэтгэл ба намын байгууллагуудын үүрэг. Ардын үндэсний эрх. 1934. №71.
32. Улсын санхүү ба албан татварын тухай. Ардын үндэсний эрх. 1936. №94.
33. Улсын санхүүгийн ба арвилан хэмнэх бодлогыг эрс хатуугаар биелүүлье. Ардын үндэсний эрх. 1933. №48, 49.
34. Улсын санхүүгийн тухай. Үнэн. 1928. №11.
35. Улсын арвилан хэмнэх бодлогыг биелүүлье. Үнэн. 1933. №42.
36. Улсын санхүүг хэрхэн зузаатгах тухай. Үнэн. 1929. №63.
37. 1932 оны мал тариалангийн албан татварын тухай. Үнэн. 1932. №205.
38. Хувьсгалын 15 жилийн ой ба санхүүгийн зорилт. Ардын үндэсний эрх. 1936. №84.
39. Худалдаа үйлдвэрээс хураах татварын хуулийн тухай. Ардын үндэсний эрх. 1934. №23.
40. Цэргийн татварын хуулийг зөвөөр биелүүлье. Ардын үндэсний эрх. 1935. №41.
41. Цэргийн тусгай татварын хуулийг биелүүлье. Үнэн. 1936. №44.
42. 1936 оны 5 дугаар сарын 22-ны дээд лам нараас тусгай татвар хураах түр дүрмийн тухай. Ардын үндэсний эрх. 1936. №64.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Үндэсний хувьсгалын 13 жилийн ой ба Бүгд Найрамдах
засгийн 10 жилийн ойн альбом.

НТА. ф. 1.	д. 3.	хн. 1	х. 5
НТА. ф. 1.	д. 5.	хн. 101.	х. 67.
НТА. ф. 4.	д. 1.	хн. 364.	х. 79.
НТА. ф. 4.	д. 1.	хн. 242.	х. 20
НТА. ф. 4.	д. 1.	хн. 409.	х. 51.
НТА. ф. 4.	д. 1.	хн. 187.	х. 179.
НТА. ф. 4.	д. 6.	хн. 123.	х. 30, 33.
НТА. ф. 4.	д. 6.	хн. 10.	х. 16.
УТТА. ф. 1.	д. 2.	хн. 599.	х. 72.
УАБХЕГ-ын архив.		хн. 1175.	11 хавтас

Үнэн. 1934. 9. 8.

Үнэн. 1931. 5. 6. №102.

Үнэн. 1934. 11. 9.

Үнэн. 1936. 4. 22.

Үнэн. 1936. 5. 5.

Үнэн. 1936. 11. 17

Үнэн. 1937. 7. 8.

Ардын үндэсний эрх. 1935. 4. 25.

МАХН-ын IX их хурлын дэлгэрэнгүй тайлан. УБ. 1984.

БНМАУ-ын IV—XX Бага хурал, хэвлэмэл.

